



Implemented by:



In cooperation with:



MINISTRY OF ENVIRONMENT
AND TOURISM

Монгол Улс дахь Тусгай хамгаалалттай газар нутгийн системийн

**Байгаль орчны боловсрол,
Мэдээллийн Үндэсний Стратеги**

**Манфред Оепен
ACT Assist GmbH**

2020 оны 8 дугаар сар

Агуулга

Оршил

1. Нөхцөл байдал
2. Мэдээллийн стратегийн тухай ойлголт
3. Байгаль орчны боловсрол, Мэдээлэл харилцааны стратеги
 - 3.1 Нөхцөл байдлын үнэлгээ, асуудлын тодорхойлолт
 - 3.2 Зорилтот бүлэг, Мэдлэг-Хандлага- Дадлын (МХД) дүн шинжилгээ
 - 3.3 Мэдээлэл, харилцааны зорилт
 - 3.4 Мэдээлэл, харилцааны стратеги төлөвлөлт
 - 3.5 Хамтын ажиллагаа
 - 3.6 Мэдээллийн хэрэгслийн сонголт, хольц
 - 3.7 Мессежийн загвар
 - 3.8 Мэдээллийн медиа бүтээгдэхүүн хөгжүүлэлт, урьдчилсан туршилт
 - 3.9 Медиа бүтээгдэхүүний ашиглалт ба хэрэгжүүлэлт
 - 3.10 Процессын баримтжуулалт, Мониторинг үнэлгээ
4. БОБМХС Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хавсралт

Хавсралт1 SPACES төсөл хэрэгжих Баруун Монголын бүс нутагт оролцогч талуудтай зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын үр дүн (Хар-Ус нуур, Хөх сэрхийн нуруу, Мөнх Хайрхан, Мянган угалзат, Хомын тал)

Хавсралт2 SPACES төслөөс дэмжих бусад ТХГ-ын ажилтнуудтай зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын үр дүн (Горхи Тэрэлж, Хан Хэнтий, Орхоны хөндий)

Хавсралт3 Улаанбаатар хотноо донор байгууллагуудтай зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын үр дүн

Хавсралт4 Улаанбаатар хотноо ТББ-уудтай зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын үр дүн

Хавсралт5 Улаанбаатар хотноо хэвлэл мэдээллийн байгууллагуудтай зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын үр дүн

Оршил

Энэхүү тоймыг 2020 оны 1-2 дугаар сард(улиралд) гүйцэтгэсэн чадавхын шаардлагын үнэлгээний явцад оролцогч талуудтай авч хэлэлцсэн асуудлуудад үндэслэн БОАЖЯ-ТХНУГ-аас өөрийн БОБМХС үйл ажиллагаанд тусгах тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлэхээр бэлтгэлээ.

1 Гол асуудлууд

- **Улс төр,-ийн хүсэл зориг, санхүүжилт, хүний нөөц дутмаг** : Нөөцийн газрын олонх ажилтнуудтай ярилцахад,нэг талаасаа санхүүжилт дутмаг, хүн хүчний хүрэлцээгүй нөхцөлд илүү олон ТХГН байгуулах болсон шалтгааныг ойлгохгүй байгаагаар илэрхийлж байв. Зарим нь Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, зохицуулалтууд “байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг” зөвшөөрөх ө.х. Монголын нүүдлийн мал аж ахуйн тоо толгойг хязгаарлах боломжтой болох талаар санаа зовж буйгаа илэрхийлж байв.
- **ТХГ, газар ашиглах хууль зохицуулалтын талаарх олон нийтийн мэдлэг дутмаг**: ТХГ-дын ажилтнууд болон голчлон хуучирсан Мэдээллийн Төвүүдээс ихэвчлэн чанар, хүртээмж муутай албан бус БОБ-ыг сургууль, эко-клуб, орон нутгийн оршин суугчид, зочид жуулчдад хүргэдэг байна. Энэ дутагдалтай байдал нь тус улсын ТХГ-дын эрдэм шинжилгээ сургалтын байгууллага,мөн бусад сонирхогч талуудын хүний нөөцөд БОБ ур чадвар, арга зүйг дээшлүүлэх, ж.нь: холбоотой тоглоом, дасгал, дүрт тоглолт зэрэг БОБ-ын интерактив арга хэрэгсэл хөгжүүлэх бололцоо муугаас улам гүнзгийрсээр байна.
- **Бэлчээрийн доройтол, талхлагдалт**: Мал сүрэг, бэлчээрийн менежментийн зохисгүй байдлаас шалтгаалан хортон шавьж устгал хангалтгүй, усны хагалбар, ургамал хамгааллын асуудлууд шийдвэрлэгдээгүй байна. Үүнтэй ижлээр, байгалийн нөөцийг хэт ашиглалттай холбоотой хууль бус ан агнуур, загасчлал, мөн түлшний бус ойн бүтээгдэхүүний олборлолтоос шалтгаалсан ойн түймэр түгээмэл гардаг байна.
- **Даацаас хэтэрсэн аялал жуулчлал**: Аялал жуулчлалаас байгаль орчны бохирдол, хөрсний доройтол, түүх, соёлын өвийн дурсгалт газрууд устах зэрэг сөрөг нөлөөлөл учруулж байна. Гэвч ТХГ-ын удирдлагын хувьд аялал жуулчлал нь санхүүжилтийн найдвартай эх үүсвэр юм. Чадварлаг хөтөч, гадаад хэлний орчуулагчид болон бусад үйлчилгээний дутагдалтай байдлаас шалтгаалан орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид, иргэд аялал жуулчлалд багахан оролцоотой.

Зөвлөлдөх санал асуулгын дээрх тоймын үр дүн нь 2019 онд НҮБХХ-ийн ENSURE төслөөс 13 сумдад малчид, гол оролцогч талуудын дунд явуулсан МХД судалгааны үр дүнгээр баталгаажсан болно.

2 Зорилтот бүлэг

Үндсэн зорилтот бүлгүүд

- бодлогоор дамжуулан санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх замаар дээрээс доош нөлөөлж чадах **улс төр, шийдвэр гаргах төвшнийхэн**;болон
- уламжлалт БОБ, мэдээллийн хөтөлбөр, арга хэмжээгээр (infotaining) дамжуулан Монгол Улсын ТХГ нутгийн систем, түүгээр хамгаалагдах экосистем, биологийн олон янз байдлын ач холбогдлын талаар ойлголтыг сайжруулан доороос дээш нөлөөлөх нөлөө бүхий **залуу үе**.

Хоёрдогч зорилтот бүлэг нь

Мэдээллийн стратеги товчоор

Үе шат 1 Үнэлгээ

- o1 Нөхцөл байдлын үнэлгээ, асуудлын тодорхойлолт
- o2 Зорилтот бүлэг, Мэдлэг-Хандлага-Дадлын (МХД) дүн шинжилгээ
- o3 Мэдээллийн зорилт

Үе шат 2 Төлөвлөлт

- o4 Нөөцийн төлөвлөлт
- o5 Түншлэгчдийн оролцоо
- o6 Мэдээллийн хэрэгслийн сонголт, хольц

Үе шат 3 Боловсруулалт

- o7 Мэдээлэл бэлтгэх
- o8 Мэдээлэл боловсруулалт, урьдчилсан туршилт

Үе шат 4 Үйл ажиллагаа баҮр дүн

- o9 Мэдээллийн хэрэгслийг ашиглахба хэрэгжүүлэх
- o10 Процессын баримтжуулалт, Мониторинг ба Үнэлгээ (МбаҮ)

- ТХГ-д нөлөө бүхий байгалийн бусад нөөцийн ашиглагчид болохын хувьд ТХГ-ын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээ болон хамгаалалтын бүсэд **оршин суугчид** болон малчид анчид нэгэн төвшинд; мөн
- ТХГ-ын **жуулчид, зочидтой** нягт харилцах, бизнес, ажил үйлчилгээ нь ТХГ-ын биологийн олон янз байдал, эрүүл экосистемээс хамаарал бүхий хувийн салбарын **аялал жуулчлалын компаниуд** болно.

3 Мэдээлэл, харилцааны зорилт

Үндсэн зорилтот бүлэгт гол асуудлаар хүргэх мэдээлэл, харилцааны зорилтуудыг 12 дахь талд 3.3 бүлэгт жагсаав. Зорилтууд нь БОБ-ын цаашдын арга хэмжээгээр бий болгох мэдлэг (М), хандлага (Х), дадал (Д) орох өөрчлөлтөөр илэрхийлэгдэнэ.

Жишээ нь, “ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг” гэсэн асуудлын мэдээлэл, харилцааны зорилтыг доорх байдлаар илэрхийлж болно:

Асуудал	Зорилтот бүлгүүд	Мэдээлэл, харилцааны зорилт
ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ Сургуулийн багш нар, сурагчид ■ Эко-клубүүд ■ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид/мэдээллийн төвүүд ■ Орон нутгийн иргэд/малчид ■ Хамгаалалтын бүсийн зөвлөлүүд ■ Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ■ ТББ-д ■ Аялал жуулчлалын компаниуд 	<p>К ТХГ-ын байршил, ёс зүйн дүрэм, хэрхэн зохистой аялж, зорчих талаар мэдээллийг олон нийтэд танилцуулах, ТХГ-ын экосистемийн үйлчилгээ, хүний үйл ажиллагааны нөлөө, хамаарлын талаарх ойлголтыг дээшлүүлэх</p> <p>А Байгаль орчинтой холбоотой Монгол соёлын өвөөр бахархах, хайрлах, уламжлан өвлөх сэдэл төрүүлэх</p> <p>Р ТХГ-ын гадаа орчинд зохион байгуулах АББОБ-ын заах арга зүйн чанарыг сайжруулах</p> <p>Жуулчдад зориулсан хэвлэмэл, цахим, сайт дах мэдээллийг нэмэгдүүлэх</p> <p>Аялал жуулчлалын компаниуд, хөтөч нарыг ёс зүй, хог хаягдал, эрүүл ахуйн боловсролыг түгээхэд сургах.</p>

4 Нөөц төлөвлөлт

БОБМХС хэрэгжүүлэлтэд цаг хугацаа, хүний нөөц, санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай. Эдгээр нөөцийг БОАЖЯ-ТХНУГ-ын БОБ-ын бүтээгдэхүүн, хэлбэрийг удирдан зохион байгуулж, санхүүжүүлэх чадавхад тохируулан үйл ажиллагааны төлөвлөгөөнд бодитойгоор тодорхойлох шаардлагатай (4 бүлгийг үз). БОБМХС болон холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөөнд өнөөгийн хэрэгжүүлж буй БОБ-ын бүтээгдэхүүн, тэдгээрийн хэлбэрүүд, мөн ойрын хугацаанд бусад талуудаас хэрэгжүүлэх бусад хөтөлбөрийг системтэйгээр нэгтгэн тусгах шаардлагатай (**3.5 болон 3.6 бүлгийг үз**).

5 Хамтын ажиллагаа

БОАЖЯ-ТХНУГ-ын хязгаарлагдмал санхүүжилт, хүний нөөцийн бололцооноос хамааран БОБ-ын үйл ажиллагааг хамтран санхүүжүүлж хувь нэмэр оруулах стратегийн түншлэл байгуулах зайлшгүй шаардлагатай. Жишээ нь ГОУХАН-ийн SPACES хөтөлбөрөөс 2020-2021 онуудад БОБ-ын чиглэлээр медиа бүтээгдэхүүн, сургалтын гарын авлага, сургалт, хэрэгслүүдийг бэлтгэх бөгөөд санхүүжилтийн хэлэлцээрээр хэвлэл мэдээллийн чиглэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд хувь нэмэр оруулах болсон. Үүнээс гадна БОБ-д хувь нэмэр оруулах НҮБХХ-ийн ENSURE төсөл, ЗААХН, ДБХС зэрэг бусад түншүүдийн мэдээллийг **3.6 бүлэгт** жагсаав.


6 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хольц

Судалгаа, туршлагаас үзэхэд олон нийтийн, бүлгийн, хувь хүн хоорондын харилцааны аргуудыг хослуулан хэрэгжүүлэх нь зардалд хэмнэлттэй байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг зорилтот бүлгийн мэдээлэл олж авах дадал, сонгон хэрэглэх мэдээллийн эх үүсвэр, хүрэлцээ, мэдээллийн хэрэгслийг

ашиглах арга барил, мэдээллийн сүлжээ, бүлгийн харилцааны зан үйлд нийцтэйгээр сонгох шаардлагатай.

Зорилтот ашиг хүртэгчдийн бүхий л зорилтыг хангах нэг мэдээллийн хэрэгсэл гэж үгүй. Иймээс төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл нь харилцан бие биенээ нөхөх шаардлагатай. Тус бүр өөрийн онцгой шинж, тодорхой давуу талтай тул тодорхой зорилтот нийцүүлэн ашиглахад давуу талыг бий болгоно.

ГОУХАН, ЗААХН, ДБХС, НҮБХХ-ийн ENSURE төслүүдийн зүгээс БОБМХС-д (3.5 бүлгийг үз) оруулж буй хувь нэмэр нь БОБМХС-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөний эхлэх цэг болж болох юм. (4 бүлгийг үз).



Жишээ нь, “ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг” гэсэн асуудлын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хольцыг доорх байдлаар тодорхойлж болно:

Асуудал	Үндсэн бүлэг	Зорилтот	Хэвлэл мэдээлэл, харилцааны суваг, суралцах дэмжлэг гэх мэт.
ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг	<ul style="list-style-type: none"> Сургуулийн багш нар, сурагчид Эко-клубүүд ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид/мэдээллийн төвүүд Орон нутгийн иргэд/малчид Хамгаалалтын бүсийн зөвлөлүүд Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ТББ-д Аялал жуулчлалын компаниуд 		<ul style="list-style-type: none"> Албан бус Байгаль орчны боловсролын (АББОБ) хэрэгсэл, үүний дотор багш нар, байгаль хамгаалагчид, залуус, гадаа орчинд зохион байгуулах хөтөлбөрийн АББОБ-ын сургагч багш бэлтгэх (СББ) зэрэг. Сургуулиудын драмын дугуйлангаар дамжуулан ТХГ-тай холбоотой театрын тоглолт, жүжиг ТХГ-ын ёс зүйн дүрмийн мэдээллийн самбар, хэвлэмэл болон цахим мэдээлэл Уран бүтээлийн уралдаан, үүний дотор сургууль, уран бүтээлчид, хувийн секторын НХ-ын хүрээнд ТХГ-дын үйлчилгээний талаар боловсрол мэдээлэл, бичлэгийн тэмцээн зохион байгуулах ТХГ-ын хялбар ойлгомжтой веб хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээний компанит ажил Аялал жуулчлалын компаниудад ТХГ-ын танилцуулга, ёс зүйн журмын танилцуулга хүргүүлэх Бүргэдийн, тогоруун наадам гэх мэт наадам, үзэсгэлэнгийн арга хэмжээгээр орон нутгийн оршин суугчидтай биечлэн уулзах ТХГ-д зориулсан комикс, апп зэргийг хослуулан “Ногоон паспорт” гаргах И-Шувуу (E-Bird) зэрэг гар утасны мессеж, апп ашиглан иргэдэд шинжлэх ухаанчаар танилцуулна Залууст зориулсан QR код ашигласан VR зэрэг танилцуулга, комик боловсруулах Хөдөлгөөнт видео клип (What’s up, Facebook мессежээр дамжуулан)

7 Мессеж

Мэдээлэл харилцааны стратегийн үр дүнтэй байдал нь голчлон зорилтот бүлгийн анхаарлыг татах, тэдэнд ойлгогдох шинж чанараас хамаардаг. Мэдээллийг амжилттай хүргэхийн тулд нийгмийн маркетингийн үйл ажиллагаанд өргөн ашиглагдах энгийн хялбар байх *KISS (Keep it short and simple)* болон зорилтот бүлгийн *Анхаарлыг* орж, *Сонирхлыг* татан, *Хүсэл* төрүүлэн, *Үйлдэл* хийлгэх *AIDA (Attention, Interest, Desire, Action)* зарчмуудыг баримталснаар зорилтот, тогтвортой үйл ажиллагаанд хүрнэ. Ихэнх хүмүүс ТХГ-тай холбоотой буюу төвөгтэй асуудлыг сонирхох нь ховор байдаг. ТХГ-тай холбоотой мэдээллийг харах буюу сонсох тохиолдолд тэд “Надад, миний бүлэг, хамт олонд энэ ямар хамааралтай вэ? Надад, миний хүрээлэлд энэ хэрхэн нөлөөлөх вэ?” зэргээр ашиг тус, урамшууллын тухай сонирхох болно.

Жишээ нь, “ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг” гэсэн асуудлын хэвлэл мэдээллийн хэрэгслийн мессежийг доорх байдлаар тодорхойлж болно:

Асуудал	Үндсэн Зорилтот бүлэг	Мессеж
ТХГ-ын талаар олон нийтийн мэдлэг дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ Сургуулийн багш нар, сурагчид ■ Эко-клубүүд ■ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид/мэдээллийн төвүүд ■ орон нутгийн иргэд/малчид ■ хамгаалалтын бүсийн зөвлөлүүд ■ орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ■ ТББ-д ■ Аялал жуулчлалын компаниуд 	<p>К ТХГ-ын тухай мэдэхэд илүүдэхгүй 10 баримт Байгаль орчин таны ирээдүй, эрүүл мэнд, сайн сайханд хэрхэн нөлөөлөхийг мэдэх</p> <p>А Амьтан, ургамал, байгалийн тогтцыг хайрлан хамгаалах Монголчуудын соёлын өвөөр бахархах Сайн сайхан маргаашийн төлөө бид өнөөдөр ! Эгог бус экологийг сонгох! Зөвхөн хувийн сонирхлоо бус, ТХГ-ыг бүхэлд нь харах Байгаль орчин таны төлөө бус, та байгалийн төлөө юу хийж чадах вэ</p> <p>Р Тодорхой ТХГ-д гадаа зохиогдох сонирхолтой ABC үйл ажиллагаа/ байгаль орчны XYZ санаачлагад оролцох Мэдээллийн самбар босгож, боловсролын мессежийг түгээх</p>

8 Медиа бүтээгдэхүүн боловсруулах

БОБМХС-ийн эхний шатанд сонгосон медиа бүтээгдэхүүн, материалыг олноор боловсруулахыг зөвлөдөггүй. Медиа бүтээгдэхүүнийг төлөвлөж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэн, мэдээллийн хэрэгслийг зөвлөмжийн дагуу зохистой ашиглан, зохицуулснаар мультимедиа мэдээлэл, харилцааны стратеги амжилттай хэрэгжих илүү боломжтой. Боломжтой тохиолдолд энэ процесст оролцогч бүхий л талуудыг зохистойгоор сургах шаардлагатай. Стратеги хэрэгжүүлэлтийн нөлөө, үр дүнг үүний салшгүй хэсэг болох форматив болон нийлмэл үнэлгээний аргаар үнэлэх нь зүйтэй (**3.10-р бүлгийг үз**).

БОАЖЯ-ТХНУГ-ын ГОУХАН, ЗААХН, ДБХС, НҮБХХ болон бусад түншүүд ТХГ-тай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн харилцааны суваг, суралцахад дэмжлэг үзүүлэх мэдээллийн хөгжүүлэлт, боловсруулалтын ажлыг эхлээд байна. (**3.5 ба 3.6-р бүлгийг үз**). Иймээс, сайтар зохицуулагдсан олон-оролцогч талууд бүхий арга барилыг Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа ашиглах нь зүйтэй (**4 бүлгийг үз**).

9 Мэдээллийн хэрэгслийн ашиглалт

Мультимедиа мэдээлэл харилцааны стратегийн хэрэгжүүлэлтэд чухал үйл ажиллагааны хариу сэтгэгдлийг зохион байгуулагчдад даруй хүргэж, үүгээрээ шаардлагатай бол стратегид залруулга, өөрчлөлт хийх боломж олгох сайн мэдээллийн удирдлагын систем шаардлагатай. Энэ мэдээллийн систем нь мөн, ихэвчлэн нэгэн зэрэг зохион байгуулах шаардлагатай, ялангуяа БОАЖЯ-ТХНУГ-ын түншүүд болох ГОУХАН, ЗААХН, ДБХС, НҮБХХ зэрэг байгууллагуудын өөр өөр төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэх, олон төрлийн үйл ажиллагааг зохистойгоор зохицуулах үүрэгтэй байна (**3.5 ба 3.6 бүлгийг үз**).

Боломжтой бол уралдаан тэмцээнд түрүүлсэн, эсвэл байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд оролцсоноор бахархуулах, олон нийтэд таниулах зэргээр мөнгөн бус урамшуулал хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн төрөл бүрийн мэдээлэл, харилцааны сувгууд хоорондоо, ж.нь, театраар түүх өгүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэтгэл хөдлөм мэдээллийг давтах зэргээр харилцан уялдаж, дэмжих шаардлагатай.

10 Мониторинг ба үнэлгээ

БОБМУ стратеги төлөвлөлтийн бүхий л шатанд тасралтгүй үнэлгээ хийх шаардлагатай. Үнэлгээний гол анхаарал нь бүхий л холбоотой үйл ажиллагааг үр ашиг, үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд, хамгийн гол нь ерөнхий стратегид үзүүлэх, нөлөөлөл үр дүнд төвлөрөх шаардлагатай.

Ихэвчлэн, гол зорилтот бүлгийн мэдлэг, хандлага, дадлын МХД судалгааг төсөл буюу стратегийг хэрэгжүүлэхийн өмнө, эхэлмэгц, мөн төгсгөлд давтан хийдэг. Ийм мэдлэг, хандлага, дадалд орсон өөрчлөлтийн өмнөх/дараах төлөвийн судалгаа нь хэвлэл, мэдээллийн сувгийн үр нөлөөлөл, БОБ арга хэмжээний чиглэлээр ашигласан сургалтын материалд хяналт, үнэлгээ хийхэд онцгой ач холбогдолтой.

Үйл ажиллагааны төлөвлөгөө

БОАЖЯ-ТХНУГ-ын зүгээс БОБМУС Үйл ажиллагааны төлөвлөгөөг ГОУХАН-ийн SPACES баг болон бусад оролцогч талуудтай хамтран зохих ажлын хэсэг байгуулах замаар хамтран боловсруулах нь зүйтэй. Энэ нь сайтар зохицуулагдсан олон-оролцогч тал бүхий тогтолцоог бүрэлдүүлэх бөгөөд, үүний үр дүнг Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу мэдээлэл, сургалтын материал бэлтгэх цаг хугацаа, хүн хүч, төсөв зэрэг нөөцийн шаардлагад тусгана.

1. Нөхцөл байдал

Монгол орны өргөн уудам нутаг дэвсгэр амьтан, ургамлын олон зүйлийн амьдрах орчныг бүрдүүлдэг. Энэхүү биологийн олон янз байдал нь Монгол улсын эдийн засаг, соёл, хөгжлийн суурийг бүрдүүлнэ. Биологийн олон янз байдлыг хамгаалахын тулд засгийн газраас улсын нийт нутаг дэвсгэрийн бараг 30 шахам хувьд үндэсний болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг (ТХГ) байгуулаад байна. Гэвч, цаг уурын өөрчлөлт, байгалийн нөөцийн ашиглалт нь энэхүү өргөн хэмжээний хамгаалалттай газар нутгийн биологийн олон янз байдал, экосистемд заналхийлэл учруулж байна.

Тусгай хамгаалалттай бүсийн ихээхэн хэсэгт хөдөө орон нутгийн иргэд оршин суудаг. Тэдний амьдралын чанар нь тусгай хамгаалалттай бүс нутгийн экосистемийн үйлчилгээний бүрэн бүтэн байдлаас ихээхэн шалтгаална. Гэвч, тусгай хамгаалалттай бүс нутгийн систем нь өнөөг хүртэл байгаль орчинд учруулах хохирлоос бүрэн сэргийлж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангаж чадахгүй байна.

Иймээс, SPACES төслөөс Монгол Улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам (БОАЖЯ) болон түүний Тусгай Хамгаалалттай Нутгийн Удирдлагын Газарт(ТХНУГ) тусгай хамгаалалттай газар нутгийн системийн тогтвортой хөгжлийн нөхцөл, удирдлагын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлж байна. Төслөөс биологийн олон янз байдлыг хамгаалан, амьжиргааны төвшнийг хадгалсан байгаль орчинд ээлтэй тусгай хамгаалалттай бүсийн удирдлагын урьдчилсан шаардлагыг тодорхойлох юм.

Бусад арга хэмжээний зэрэгцээ, төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэл, материалаар дамжуулан байгаль орчны боловсрол, мэдээллийг түгээн ТХГ болон хамгаалалтын бүсэд оршин суугчдад дэмжлэг үзүүлэн, аялагчид, зочид болон экспертүүдэд экосистемийн хамгаалалтын ач холбогдлыг таниулах юм.

Энэ зорилгоор SPACES төслөөс ТХГ-ын системд зориулсан зорилтот бүлгийн байгаль орчны боловсрол, мэдээлэл харилцааны стратегийг (БОБМХС) хөгжүүлэхэд ACT Assist компанийг оролцуулж байна. БОБ арга хэмжээний зорилтот үр дүн нь экосистемийн үйлчилгээ, түүний эдийн засаг, соёлын ач холбогдлын талаар мэдлэг сайжрах явдал юм. Үүнтэй холбоотойгоор ТХГ-ын орон нутгийн экспертүүд, орон нутгийн иргэд, зочдын эерэг хандлага, дадал нь тусгай хамгаалалттай бүс нутгийн тогтвортой байдлыг үр дүнтэй хангах, экосистемийн үнэ цэнийг олон нийтийн тусын тулд өсгөх, хамгаалах анхдагч нөхцөл болох юм. ТХГ-ын захиргаа, төрийн бус байгууллагын (ТББ) хамтын зүй зохистой ажиллагаа нь олон төвшинд хянаж, туршигдсан БОБ-ын арга, хэлбэр, бүтээгдэхүүнийг бэлтгэн гаргах ажлыг сайжруулна.

БОБ-ыг бэлтгэхдээ ACT Assist-аас холбогдох оролцогч талуудын дунд системт чадавх, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдал, асуудлыг тодорхойлох дүн шинжилгээг Улаанбаатар хот, Ховд аймгуудад 2020 оны 01/02 дугаарсард гүйцэтгэсэн. БОБ-ын голлох үйл ажиллагаатай холбоотой ярилцлагын зааварчилгаа, ажлын байрны дэмжлэгийн багц стандартад суурилсан 35 гаран удаагийн зөвлөлдөх

уулзалтыг оролцогч талуудтай, үүний дотор ТХГ-ын ажилтнууд (17), донор (7), ТББ-уудтай (8), хэвлэл мэдээллийн төлөөлөгчидтэй (3) зохион байгуулсан.

2. Мэдээллийн стратегийн тухай ойлголт

Монгол улсын ТХГ-ын системийн байгаль орчны боловсролын үндэсний стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө нь орон нутгийн хамтрагч талуудын чадавх, хэрэгцээний үнэлгээний үр дүн, дүгнэлтэд суурилсан. АСТ Assist нь ГОУХАН болон ЭЗХАХБ-ХДХ-ын 10 алхамт БОБС хэрэгслийг ашигласан. Нөхцөл байдлыг үнэлгээ, асуудлын шинжилгээнээс эхлэх энэхүү арга зүй нь нэн тэргүүнд зорилтот бүлгийн онцлог шинж, мэдлэг, хандлага, дадлыг (МХД) эхлэн тодорхойлж, үүнд үндэслэн мэдээлэл, харилцааны зорилтыг тодорхойлно (Алхам 1-3). Зорилтот бүлгийн зорилгыг тодорхой тавих нь чухал. Бүлэг 3.2-т үзүүлсэн оролцогч талуудын зураглалд боломжит бүлгүүдийг тоймлон харуулав. Энэ стратеги үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах цаг хугацаа, ажилтан, хөрөнгө зэрэг нөөцийн хэрэгцээг бодитойгоор тодорхойлон, нийгмийн сүлжээний болон маркетингийн компанит ажлууд, бусад БОБ бүтээгдэхүүн, хэлбэрийг удирдан зохион байгуулах БОАЖЯ-ТХНУГ-ын чадавх санхүүжилтэд нийцүүлэх шаардлагатай. Үүнээс гадна, БОБМХС үйл ажиллагааны төлөвлөгөөг санхүүжүүлж, дэмжлэг үзүүлэх буюу хувь нэмэр оруулж чадах боломжит түнш талуудыг таньж тодорхойлох хэрэгтэй.

Энэ нь хамгийн итгэл найдвар бүхий зорилтот бүлэгт хүрэх олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгэмд суурилсан мэдээлэл, холбооны сувгуудыг ашиглах хольцыг тодорхойлох боломжийг олгоно. (Үе шат 4-6). Ялгаатай мэдээллийн хэрэгслүүд ялгаатай үүрэг гүйцэтгэнэ, ж.нь. нийгмийн сүлжээгээр татан оролцуулахад тохирох ч суралцахад тохиромжгүй, радио, театр сэтгэл хөдөлгөм боловч бүтээлийг хийх бэлтгэл, дараагийн ажлын зардал өндөр байж болох юм. Мэдээллийн хэрэгслийн сонголт нь төсөв, үндэсний/орон нутгийн зорилтот бүлэг, хот/орон нутгийн байрлал, соёл, арга хэмжээний төрөл зэрэг олон хүчин зүйлсээс мөн хамаарна. АСТ Assist нь БОБ-ын тухай ойлголт, сургалтын бүхий л чиглэлээр Бод-Мэдэр-Хий хандлагыг баримтлан БОБ бүтээгдэхүүнийг нийтийн чиг хандлагад нийцүүлэн ж.нь видео бичлэг хийж телевизээр үзүүлж болох театрчилсан тоглолтын бүтээгдэхүүнээс эхлэн бэлтгэж байна. Интернэт холболтын хүртээмж өндөртэй, Монгол улсын хувьд нийгмийн сүлжээ, веб аппликэйшнийг SPACES төслийн мэдээлэл, харилцааны зорилт, төсөв, зорилтот бүлэгт тохируулан ашиглахад онцгой анхаарах шаардлагатай.

Ерөнхийдөө, (1)сургууль, их сургуулийн буюу хичээлийн гадуур албан бус боловсрол, боловсрол танин мэдэхүйн үйл ажиллагаагаар дамжуулан боловсрол, ур чадварыг хөгжүүлэх арга хэлбэрийг хэрэгжүүлэх,(2) нийгмийн өөрчлөлтөд чиглэсэн сурталчилгааны компанит ажлыг нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллээр явуулах (C4SC) гэх мэт, байгаль орчинд хортой дадлаас салахыг сурталчлах ажлуудыг онцгой уян хатнаар зохион байгуулах нь зүйтэй юм. Ийм хандлагыг үе тэнгийнхнээсээ илүүтэй шийдэл олж, эерэг өөрчлөлтийг өвөрмөц, амжилттайгаар бий болгосон өөрчлөлтийн түүчээдийн жишээг ашиглан шууд бус санал зөвлөмж болгох замаар нэвтрүүлж болно.АСТ Assist нь ГОУХАН-ын SPACES төсөл, түүний хамтрагч байгууллагуудад стратегийн зорилтот бүлэгт зориулсан хамгийн анхаарал татам мессежийг зохиох, үүнийг ямар төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан урьдчилан турших, БОБМҮС-ийн төлөвлөгөөт хугацаа, төсөвт багтаан бүтээх тухайд дэмжлэг үзүүлнэ (Үе шат 7-8). Энэ нь боловсруулсан мэдээлэл, материал нь зорилтот бүлэгт хамгийн үр ашигтайгаар хүрч буй байдал, стратеги зорилтдоо хүрч буй эсэх зэрэг, үр нөлөөллийг үнэлэх хүчирхэг арга хэрэгслийг ашиглан хянах боломжийг төсөл, түүний оролцогч талуудад олгоно(Үе шат 9-10). БОАЖЯ-ТХНУГ, ТХГ-ын ажилтан, мэдээллийн төвүүд болон төрийн бус байгууллагууд, буюу бусад

Мэдээллийн стратеги

ТОВЧООР

Үе шат 1 Үнэлгээ

- 01 Нөхцөл байдлын үнэлгээ, асуудлын тодорхойлолт
- 02 Зорилтот бүлэг, Мэдлэг-Хандлага-Дадлын (МХД) дүн шинжилгээ
- 03 Мэдээллийн зорилт

Үе шат 2 Төлөвлөлт

- 04 Нөөцийн төлөвлөлт
- 05 Түншлэгчдийн оролцоо
- 06 Мэдээллийн хэрэгслийн сонголт, хольц

Үе шат 3 Боловсруулалт

- 07 Мэдээлэл бэлтгэх
- 08 Мэдээлэл боловсруулалт, урьдчилсан туршилт

Үе шат 4 Үйл ажиллагаа ба Үр дүн

- 09 Мэдээллийн хэрэгслийг ашиглахба хэрэгжүүлэх
- 10 Процессын баримтжуулалт, Мониторинг ба Үнэлгээ (МбаҮ)

стратегийн хувьд чухал оролцогч талуудад энд дурдсан БОБМУС-ийн арван алхамт арга барилыг сургана.


3. Байгаль орчны боловсрол, Мэдээлэл харилцааны стратеги

Монгол Улсын ТХГ-ын байрзүй нь өргөн уудам, экосистем нь олон төрөлтэй бөгөөд зорилтот бүлэг нь мөн адил сургуулийн хүүхэд багачуудаас эхлэн бодлого боловсруулагчид хүртэл өргөн хүрээтэй тул ТХГ-ын системд зориулсан Байгаль орчны боловсрол, мэдээлэл харилцааны стратеги (БОБМХС) хөгжүүлэх нь онцгой төвөгтэй, хүнд даалгавар юм. Энэхүү нарийн төвөгтэй байдал, үүнээс үүдэн гарах асуудлаас шалтгаалан боловсруулагдах БОБМХС-ийн суурь нөхцөл нь, тодруулбал “нэг хэмжээст” арга барил ашиглах боломжгүйд оршино. Харин, үүний үзэл санаа, хэрэгжүүлэлтийг аль болох зорилтот бүлэг, нөхцөл байдалд тааруулах нь зүйтэй.

Улс орны өвөрмөц газарзүйн онцлог, нүүдлийн мал аж ахуй, соёл, уламжлал болон хүн амын сийрэг байдал нь Монгол улс хүн байгаль зэрэгцэн тогтвортой орших, доройтсон экосистем, ховордсон амьтан, ургамлыг хадгалан хамгаалах чухал орчин болох шалтгаан юм.

3.1 Нөхцөл байдлын үнэлгээ, асуудлын тодорхойлолт

Нөхцөл байдлын үнэлгээ Монгол Улсын ТХГ-ын тогтолцооны нөхцөл байдал нь маш өргөн хүрээтэй. Байрзүйн шинж чанар, экосистемийн хүрээ нь өндөр уулс, ой тайга, Евроазийн тал, нуур, гол усны хагалбар нутаг, Говь цөл, зүүнгарын тэгш талыг хамардаг. Монгол орны дөрвөн эко бүсэд, 16 экосистемийн төрөл оршин байдаг нь: дагуурын тал, хангай, Төв Азийн говь цөл, Алтай саяны уулархаг бүсийг агуулдаг. Өмнө дурдсанчлан, улс орны нийт газар нутгийн 20 гаран хувийг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн үндэсний ТХГ-ын дөрвөн ангилалд хамааруулсан байдаг.



Газар нутгийн 75 орчим хувийг бэлчээр, газар тариалангийн зориулалтаар ашигладаг, нийт нутгийн 10 орчим хувийг ой эзэлнэ. Монгол Улсын Улаан номд ан агнуур, тоо толгойн алдагдлаас ховордсон буюу нэн ховордсон нийт 110 зүйлийн амьтан 192 төрлийн ургамлыг бүртгэсэн байна. Биологийн олон янз байдлын ховордлын гол хүчин зүйл нь үндсэндээ, ойн сан, бэлчээр нутгийн доройтолд хүргэх тогтвортой бус газар ашиглалт, тогтвортой бус уул уурхайн ажиллагаа, хэт их ан агнуур, хог хаягдал, бохир усны зохицуулалт сул, ТХГ-ын зочид, аялагчдын тоо их зэрэг хүний хүчин зүйлээс хамаарч байна. Эдгээр хүчин зүйл нь Монгол улсад хурдацтай өрнөн буй уур амьсгалын өөрчлөлтийг хурдасгаж байна.

Асуудлын тодорхойлолт 2020 оны 1-2 сард хийгдсэн Чадавхын хэрэгцээний үнэлгээний (ЧХҮ) явцад Улаанбаатар хот, Ховд аймгийн холбогдох оролцогч талуудтай хийсэн ярилцлагаас дээр дурдсан асуудлын дийлэнхийг олж тодорхойлсон. Эдгээр асуудлуудыг Улаанбаатар хот, Ховд аймгаас ярилцсан оролцогч талуудаар ангилан, тэргүүлэх асуудлуудыг сонгов.

Баруун Монголын бүс дэх SPACES төслийн оролцогч талууд (Хар-Ус нуур, Хөх сэрхийн нуруу, Мөнх Хайрхан, Мянган угалзат, Хомын тал, **Хавсралт 1-ийг үз**)

- 1 ТХГ-т нэвтрэх/ан хийхэд хураадаг төлбөрийг зохисгүй ашигладаг
- 2 ТХГ-ын талаар жуулчдын мэдээлэл хангалтгүй, байгууллагын загвар, бодлогыг баримталдаггүй
- 3 Мэдээлэл, үйлчилгээний соёл муутай тул орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид/ олон нийт аялал жуулчлалд оролцоо сул
- 4 Хэлний бэрхшээлийн улмаас олон нийт жуулчидтай харилцаж чаддаггүй

- 5 Хүний хаягдал, хог, голын сав газар дахь оршуулгын газар, малын ялгадас, усан далан зэргээс шалтгаалан ТХГ-ын орчин дахь усны чанар муудаж байгаа
- 6 ТХГ-ын бэлчээрийн хүчин чадлыг тодорхойлоогүй, нэг өрхөд ногдох малын тоо толгой, бэлчээр ашиглалт өндөртэй төрөл зүйлийн тоо толгойг тодорхойлоогүйн улмаас орчны бэлчээр талхлагдсан
- 7 Хүний нөөцийн хомсдол, хэл, экосистемийн мэдлэг, GPS, зургийн камерын хэрэглээ, хөгжүүлэх байдал гэх мэт чадвар хөгжүүлэх байдал дутмаг.
- 8 Машин, GPS, радио, камер гэх мэт техник хэрэгсэл муутай.

SPACES төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх бусад ТХГ-ын ажилтнууд(Горхи Тэрэлж, Хан Хэнтий, Орхоны хөндий, Хавсралт2)

- 1 ТХГ, газар ашиглалтын зохицуулалт, үүний дотор Мэдээллийн төв хуучирсан, байгаль орчин, мэдээлэл харилцааны чиглэлээр албан бус боловсролын чанар, хүртээмж муу
- 2 Хог хаягдлын менежмент, үүний дотор ариун цэврийн байгууламж муу
- 3 Бэлчээрийн доройтол/талхлагдалт (үүний дотор малын тоо толгойн менежмент, хортон шавж устгал, бэлчээрийн зохистой хуваарилалт, усны хагалбар, ургамал хамгаалал, худаг, амьжиргааны бусад арга хэрэгсэл, ядуурал бууруулах)
- 4 Аялал жуулчлал ихэссэн
- 5 Нөөцийг хэтрүүлэн ашиглах болсон, үүнд ТБОБ-ийн хууль бус ашиглалт, ойн түймэр, шавж устгал
- 6 Зочдын менежмент муу (хатуу, зөөлөн арга хэмжээ)
- 7 Улс төрийн зориг эрмэлзэл сул, санхүүжилт, хүний нөөц дутмаг

Жишээ:

Улс төрийн хүсэл зориг дутмаг

Социализмаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш ноолуур самнах ямааны нийт сүрэгт- морь, үхэр, гэмээ, хонины тоо толгойтой харьцангуй эзлэх хувь ньэрс нэмэгдсэн. Энэ нь богино хугацаанд санхүүгийн ашигтай боловч ямааны идэшлэх хэв маягаас экологийн ноцтой үр дагавар үүснэ. Засгийн газраас мал сүргийн өсөлтийн тоо толгойг хязгаарлах зээлийн урамшууллын хөтөлбөр хэрэгжүүлэхээр амжилтгүй оролдсон. Малчид нийт малын тоо толгойг цөөлсөн ч ямааны тоо толгой буурсангүй. Үүнээс шалтгаалан бэлчээрийн даац хэтэрсэн хэвээр байна. Ямааг банкны зээлээр санхүүжүүлэх нь газар авсан тул, “банкны ямаа” гэх нэршил бий болжээ.

Улаанбаатар дахь **Донорууд, ТББ-д болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд** ерөнхийдөө ижил төрлийн асуудлуудыг арай ялгаатай дарааллаар дурдсан (**Хавсралт3-5-ыг үз**). **ТББ-д**байгалийн баялгийн төлөөх хүн, зэрлэг байгалийн зөрчилдөөнийг дурдсан бол, **хэвлэл мэдээллийн төлөөлөл** хотын байгаль орчин, ө.х. агаарын бохирдол, хог хаягдал, хот төлөвлөлт зэрэг асуудлыг нэмсэн байна.

Иймээс бүхий л оролцогч талууд санал нэгдсэн, БОАЖЯ-ТХНУГ-ын зүгээс БОБМХС-ийн тэргүүлэх зорилтдоо тусгаж болох асуудлуудыг дор жагсаав.

- **Санхүүжилт, хүний нөөц, улс төрийн зориг эрмэлзэл дутмаг:** Нөөцийн газрын олонх ажилтнуудтай ярилцахад, нэг талаасаа санхүүжилт дутмаг, хүн хүчний хүрэлцээгүй нөхцөлд илүү олон ТХ газар нутаг байгуулах болсон шалтгааныг ойлгохгүй байгаагаа илэрхийлж байв. Зарим нь мөн Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, зохицуулалтууд “байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг” зөвшөөрөх ө.х. Монголын нүүдлийн мал аж ахуйн тоо толгойг хязгаарлах боломжтой болох талаар санаа зовж буйгаа илэрхийлж байв. Бүс нутагт газрын хил хязгаарыг тодорхойлох боломжгүй, хамгаалалтын жинхэнэ зорилтыг хуулиар тодорхойлоогүй тул зарим бүсэд газар, нөөцийн ашиглалт хяналтгүй байна. Үүнээс гадна, Монголын нүүдэлчдийн бэлчээрийн малын тоо толгой, бүтцэд хязгаарлалт тавих улс төрийн хүсэл зориг дутмаг байна. Мөн, ТХГ-д нэвтрэх, ан агнах, загасчлахад хураах төлбөрийг ТХГ-д үр ашигтайгаар ашиглаж зарцуулахгүй байна.
- **ТХГ болон газар ашиглалтын зохицуулалтын талаар олон нийтийн мэдлэг хангалтгүй:** ТХГ-ын ажилтнууд, болон ихэвчлэн хуучирсан Мэдээллийн Төвүүд нь чанар, хүртээмж муутай албан бус БОБ-ыг сургууль, эко-клубүүд, орон нутгийн оршин суугчид, зочдод хүргэдэг. Энэ дутагдал нь тус улсын ТХГ-ын академик болон сургалтын байгууллагууд буюу бусад сонирхогч талуудаас БОБ сургалтын ур чадвар, арга барилаа сайжруулах ө.х. зорилтот бүлэгт тусгайлан зориулсан, үр нөлөө сайтай тоглоом, дасгал, дүрт тоглолт болон бусад интерактив

аргыг, үр дүнд чиглэсэн зорилготой байдлаар БОБ-ын сургалтын хэрэгсэлд ашиглах боломж муутай нөхцөл байдлыг улам дордуулж байна. Үүнээс гадна, зөрчил шийдвэрлэх, экосистемийн үйлчилгээ болон GPS, камер, зургийн аппарат ашиглах ур чадварын сургалт хомс байна. Олон нийтийн мэдлэгт тулгамдсан асуудал нь голчлон ж.нь. нэвтрэх төлбөр, тэмдэг, газрын зураг, ёс зүйн журам, байрлах, ан агнуур хийх, загасчлах зохицуулалттай холбоотой ТХГ-ын зочдын менежментийн чадвар, мэдээлэл дутмагаас шалтгаалдаг.


- **Бэлчээрийн доройтол, талхлагдалт:** Сүүлийн арван жилд зохистой зорилго бүхий төслүүд хэрэгжүүлж ирсэн ч, мал сүрэг, бэлчээрийн зохисгүй удирдлага болон хортон шавжийн устгал, усны хагалбар, ургамлын нөөцийн хамгаалалт хангалтгүй байдал шийдвэрлэгдээгүй байна. Үүнтэй ижлээр, байгалийн нөөцийг хэт ашиглалттай холбоотой хууль бус ан агнуур, загасчлал, мөн түлшний бус ойн бүтээгдэхүүний ашиглалтаас шалтгаалсан ойн түймэр гарах явдал түгээмэл байна. Хүний хайхрамжгүй байдлаас шалтгаалсан гал түймэр ойн бүрхүүлийг доройтуулж, улмаар хөрсний усны төвшин, шар усны үер нэмэгдэж, цөлжилт эрчимжиж байна.
- **Хэт аялал жуулчлал:** Ялангуяа, жуулчлал ихтэй ТХГ-ны бүсэд азтай ч, аягүй явдал болоод байна. Үүнтэй холбоотой үйл ажиллагаа нь байгаль орчны бохирдол, хөрсний доройтол, түүхэн болон соёлын өв дурсгалт газруудыг сүйтгэн, устах зэргээр сөргөөр нөлөөлж байна. Гэвч аялал жуулчлал нь нөгөө талаасаа ТХГ-ын захиргааны хувьд санхүүжилтийн найдвартай эх үүсвэр болдог. Гэвч, ТХГ-ын захиргаа нь хүн хүч цөөнтэй, аялал жуулчлалын туршлага багатай байна. Ур чадвартай хөтөч, гадаад хэлний хөрвүүлэгчид, болон бусад үйлчилгээ дутагдалтай тул орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид болон орон нутгийн иргэд аялал жуулчлалд оролцоо төдий байдаг. Аялал жуулчлалын компаниуд мөн нэг талдаа хог хаягдал, ариун цэврийн байгууламжийн асуудалд тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ, нөгөө талдаа асуудлын боломжит шийдэл ч болж болох юм. Тэд аялал жуулчлалын дэд бүтэц багатай аяллын бүс, зочид буудал, гэр кэмпийн орчинд дэд бүтцийн сул хөгжлийг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой бөгөөд мэдээллийн төв, газрын зураг, зөвшөөрөгдөх маршрут, тэмдгийн мэдээлэл бага байна.

Дээрх зөвлөмжүүд нь 2019 онд НҮБХХ-ийн ENSURE төслөөс захиалсан малчид, гол оролцогч талуудын дунд хийсэн МХД судалгаагаар баталгаажсан байна. Малчид бэлчээрийн талхлалт, ус, ургамлын хомсдол, бэлчээрийн доройтол, цөлжилтийг гол асуудал гэж үзжээ. Эдгээр асуудлууд, ялангуяа усны хомсдол нь цаг уурын өөрчлөлтийн нөлөөллөөр гүнзгийрсээр байна. Хүүхдүүд нь сумын төвд сурах болж, эмэгтэйчүүд, хүүхдүүд жилийн дийлэнх хугацааг төвд өнгөрөөх болсон тул олонх малчид сүргээ бэлчээрлүүлэн нүүдэллэх нь багассан байна. Энэ мал сүргээ цөө хэдэн худгийн ойролцоо бэлчээрлүүлэх болсон нь бэлчээрийн доройтол, талхлагдалтыг улам нэмэгдүүлсээр байна.

3.2 Зорилтот бүлэг, Мэдлэг-Хандлага- Дадлын (МХД) дүн шинжилгээ

1,564,116 хавтгай дөрвөлжин километр газар нутаг, 3.3 сая гаран хүн амынх нь 45 хувь нь Улаанбаатарт дангаар оршин суух Монгол Улс нь газар нутгийн хэмжээгээр дэлхийд 18-д орох бөгөөд хүн амын нягтшил хамгийн бага улс юм. Ажил эрхлэх, боловсрол эзэмшихээр хотжин төв газарт нүүн шилжих хөдөлгөөн ихтэй. Хөдөө нутгийн иргэд, голчлон мал хариулах, микро болон жижиг хэмжээний үйлдвэрлэл явуулах бөгөөд үйлчилгээ нь зөвхөн сум, аймгийн төвүүдэд төвлөрсөн байдаг.

Хөдөөгийн ядуурал, уламжлалт арга барил нь нэг талаасаа ТХГ-ын хамгаалалтын бүсийн бэлчээр, ой, зэрлэг амьтдын хэт хэрэглээний шалтгаан болно. Экоосистемийн үйлчилгээ, биологийн олон янз байдлын талаар ойлголт хомсоос гадна богино хугацаанд орлого, ашиг олох хэрэгцээ нь амьжиргаанд аюул учруулах тогтворгүй



дадал практик болоод байна. Өмнө дурдсан ноолуурын ямааны асуудал үүний нэг жишээ болно. Монгол орны бэлчээрийн аж ахуй зөвлөлтийн үед мал аж ахуйн хэлбэрт шилжиж, 1990 оны зах зээлийн эдийн засгийн шилжилтэд өртсөн. Үүний үр дүнд, малчид илүү чөлөөтэй болж, хүүхдүүд нь сургуульд суралцах хугацаанд, гэр бүл нь суурин амьдарч сум, аймгийн төвөөс төдийлөн холдолгүйгээр байгалийн баялаг, нийгмийн нөөцийг ашиглах бололцоотой болжээ. Иймээс, Монгол улсын байгаль орчны томоохон асуудал болсон бэлчээр, нүүдлийн мал аж ахуй эрхлэх боломжит газар нутгийн хомсдол нь ТХГ-ын системд мөн нөлөөлж байна.

ТХГ болон хамгаалалтын зурваст амьдарч буй хөдөө орон нутгийн иргэд нь иймээс БОБМХС-ийн гол зорилтот бүлэг юм. Энд үзүүлсэн оролцогч талуудын зураглалд гол, үндсэн, туслах оролцогчдын эзлэх байр суурийг үзүүлэв.

2020 оны 1-2 дугаар сард гүйцэтгэсэн чадавхын шаардлагын үнэлгээгээр БОБМХС-ийн гол зорилтот бүлгийг доорх байдлаар тодорхойлсныг Улаанбаатар хот, Ховд аймгийн оролцогчдын сонгосон тэргүүлэх чиглэлээр ангилан доор үзүүлээ.

Баруун Монголын бүс дэх SPACES төслийн оролцогч талууд (Хар-Ус нуур, Хөх сэрхийн нуруу, Мөнх Хайрхан, Мянган угалзат, Хомын тал, Хавсралт 1-ийг үз)

Асуудал	Зорилтот бүлэг
ТХГ-ын орлогын боломжуудыг зохистой ашигладаггүй	Засгийн газар, Орон нутгийн захиргаа, БОАЖЯ-ТХНУГ
ТХГ-ын талаар аялал жуулчлалын мэдээлэл	БОАЖЯ-ТХНУГ, Аялал жуулчлалын компаниуд, Жуулчид, Донорууд
Орон нутгийн үйлчилгээ үзүүлэгч ба олон нийт аялал жуулчлалд оролцоо сул	Аялал жуулчлалын компаниуд, Орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид ба олон нийт, Орон нутгийн захиргаа, БОАЖЯ-ТХНУГ
ТХГ-ын орчны усны чанар муудаж байгаа	Засгийн газар, БОАЖЯ-ТХНУГ, Донорууд
ТХГ-ын орчинд бэлчээр талхлагдсан	Засгийн газар, БОАЖЯ-ТХНУГ, Малчид ба анчид, Судалгаа
Хүний нөөцийн дутагдал, хүний нөөцийн хөгжүүлэлт	Засгийн газар, БОАЖЯ-ТХНУГ, ТХГ-ын захиргаа ба байгаль хамгаалагчид
Техник хэрэгслийн дутагдал	Засгийн газар, БОАЖЯ-ТХНУГ, Донорууд

SPACES төслийн хүрээнд дэмжлэг үзүүлэх бусад ТХГ-ын ажилтнууд (Горхи Тэрэлж, Хан Хэнтий, Орхоны хөндий, Хавсралт 2)

Асуудал	Зорилтот бүлэг
улс төр-ийн хүсэл зориг, санхүүжилт, ба хүний нөөц дутмаг	<ul style="list-style-type: none"> Улсын Их Хурал Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа болон холбогдох агентлагууд БОАЖЯ-ТХНУГ

Асуудал	Зорилтот бүлэг
<ul style="list-style-type: none"> ■ ТХГ, газар ашиглалтын журмын талаар олон нийтийн мэдлэг сул, БОБ, жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмж бага 	<ul style="list-style-type: none"> ■ Сургууль, эко клубүүд ■ мэдээллийн төвүүд ■ орон нутгийн иргэд ■ ТХГ-ын захиргаа ба байгаль хамгаалагчид ■ орон нутгийн засаг захиргаа ■ орон нутгийн бизнесүүд ■ ТХГ, ТХНУГ ба Сумын захиргаа ■ хамгаалалтын бүс ба олон нийтийн байгууллагууд ■ аялал жуулчлалын компаниуд
<ul style="list-style-type: none"> ■ Бэлчээрийн талхлагдалт, ойн доройтол, үүний дотор нөөцийн хэт, хууль бус ашиглалт, 	<ul style="list-style-type: none"> ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ■ малчид, анчид ба орон нутгийн иргэд ■ байгаль хамгаалагчид ■ 4-дугуйтын жолооч/моторт клубүүд ■ зочид, орон нутгийн иргэдийн дундах нөөц ба ТБОБ ашиглагчид ■ ТХГ захиргаа, байгаль хамгаалагчид ■ орон нутгийн захиргаа
<ul style="list-style-type: none"> ■ Хэт их жуулчлал, үүнд хог хаягдлын менежмент, эрүүл ахуйн байгууламж зохистой бус 	<ul style="list-style-type: none"> ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ■ аялал жуулчлалын компаниуд ■ зочид ■ орон нутгийн захиргаа ■ орон нутгийн иргэд ■ сургуулиуд ■ хатуу хог хаягдлын менежментийн компаниуд

Улаанбаатар хот дахь **донор, ТББ, болон хэвлэл мэдээллийн байгууллагууд** ерөнхийдөө зорилтот бүлэгтэй ижил төстэй асуудлуудыг дурдсан (**Хавсралт 3-5**-ыг үз) боловч, хувийн сектор, холбогдох ТББ-ууд, нийгэмд суурилсан байгууллагуудад илүү анхаарал хандуулах хандлагатай байна. **ТББ-д** залуус, хууль сахиулах байгууллагуудыг, харин **хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл нь** сэтгүүл зүй, уран бүтээлчдийн үүрэг хариуцлагыг онцлон дурдсан байна.

Үндсэн хоёр зорилтот бүлгийн асуудлаар ярилцлагад оролцогч бүх талууд санал нэгдсэн бөгөөд БОАЖЯ-ТХНУГ-аас өөрийн БОБМХС-даа хоёр талт арга барил баримтлан тэргүүлэх чиглэлийг тодорхойлж болно:

- бодлогоор дамжуулан санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх замаар дээрээс доош нөлөөлж чадах **улс төр, шийдвэр гаргах төвшнийхэн**;болон
- уламжлалт БОБ, мэдээллийн хөтөлбөр, арга хэмжээгээр (infotaining) дамжуулан Монгол Улсын ТХ газар нутгийн систем, түүгээр хамгаалагдах экосистем, биологийн олон янз байдлын ач холбогдлын талаар ойлголтыг сайжруулан доороос дээш нөлөөлөх үр дүн бүхий **залуу үе**.

Үүнээс гадна ТХГ-ын асуудал, асуудал шийдвэрлэлтийн аль алинд нөлөөтэй хоёр өөр шинж чанар бүхий зорилтот бүлгийг ярилцлагад оролцогчид дурдсан нь:

- ТХГ-д нөлөө бүхий байгалийн бусад нөөцийн ашиглагчид болохын хувьд ТХГ-ын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээ болон хамгаалалтын бүсэд **оршин суугчид** болон малчид, анчид нэгэн төвшинд; мөн
- ТХГ-ын **жуулчид, зочидтой** нягт харилцах, бизнес, ажил үйлчилгээ нь ТХГ-ын биологийн олон янз байдал, эрүүл экосистемээс хамаарал бүхий хувийн салбарын **аялал жуулчлалын компаниуд** болно.

БОАЖЯ-ТХНУГ болон ТХГ-ын тухайд, эдгээр бүлгийн хоорондын ялгаа нь стратегийн ач холбогдолтой:

Аль бүлэгтэй ажилласнаар илүү амжилтад хүрэх вэ?Аль ажиллагаа нь илүү үр дүнтэй вэ? Аль бүлэгт хүрэхэд хялбар байх вэ? Аль бүлгийн ТХГ-тай холбоотой мэдлэгийг дээшлүүлж, хандлагыг өөрчлөн,

дадлыг өөрчилж чадах вэ? ТХГ-ын талаар мэдлэг дээшлүүлэх, хандлага, дадлыг өөрчлөх зорилготой үйл ажиллагаанаас аль бүлэг илүү ашиг олж, алдагдал хүлээх вэ?

Ийм стратегийн асуудлын тухайд, **улс төрийн шийдвэр** гаргагчид бодлого, хууль хэрэгжүүлэлтийн хүрээнд тогтолцоо, зохицуулалтад нөлөөлөл өндөртэй. Харин тэдэнд хүрч шинэ мэдээлэл нөхцөлийг танилцуулан чиглэлийг өөрчлөхөөр ятган таниулахад хэцүү байж болох ч зорилтот үр дүнд хүрэхийн тулд энэ бэрхшээлийг даван дуулах нь үнэ цэнэтэй юм. Монгол орны ирээдүй болсон **залуу үед** мэдээлэл хүргэх, сургах, хандлага, дадлыг өөрчлөхөд хялбар бөгөөд ногоон сургууль, эко-кэмп, БОБ-ын аяллын арга хэмжээнүүд амжилттай хэрэгжих боломжтой. Иймээс БОБ арга хэмжээ сургалтууд- үүний дотор сургагч багшийн сургалт, БОБ арга, хэрэгслийн үндэсний болон орон нутгийн чадавхыг хөгжүүлэх нь зүйтэй юм. Дор хаяж **орон нутгийн** хүн амын өндөр настай бүлэг нь тархай бутархай оршин суух тул тэдэнд мэдээлэл хүргэхэд хэцүү бөгөөд тэд шинэ баримт, шинэлэг зүйлсийг хүлээн авах, чиглэлээ өөрчлөн эрсдэл хүлээх дургүй байдаг. Энэ зорилтот бүлэгт хүрэхийн тулд залуу үед зориулсан хөтөлбөрийн цаашид дамжин түгээгдэх шинэ чанарыг ашиглан, орон нутгийн ТББ, малчид, хамгаалалтын бүсийн зөвлөлийн шууд харилцаагаар дамжуулан, олон нийтэд хүргэх мессежээр дэмжлэг болгон, донорын нийгэмлэгийн санхүүжилт, хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлах шаардлагатай. **Аялал жуулчлалын оператор компаниуд** – мөн орон нутгийн хөтөч, бусад үйлчилгээ үзүүлэгчдийн бизнес загвар ТХГ-ын эрүүл байдлаас хамаарах тул, үүнд анхаарах нь зүйн хэрэг. Кэмп, дэлгүүр, морь унах, алхалт, болон бусад аялал зохион байгуулахдаа тэд зочид, жуулчидтай бүр байгаль хамгаалагчид, ТХГ-ын захиргаанаас ч илүү ойр нягт ажилладаг. Иймээс тэд, **зочид, жуулчдад** чиглэсэн арга хэмжээнд шууд зуучлах чухал үүрэгтэй, үүнд ж.нь. ёс зүйн дүрэм, хог хаягдал, , ариун цэврийн байгууламжийн менежмент, жуулчдын мэдээлэл, тэмдэг, самбар зэргээр хангахаас гадна- **нийтийн үйлчилгээ үзүүлэгчийн хувьд** тогтвортой орлого бий болгох үйл ажиллагаа явуулах үүрэгтэй.

Жишээ:

Зөв зуучлагчийг сонгох нь

2019 онд НҮБХХ-ээс зохион Горхи, Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт хийсэн МХД судалгааны үр дүнгээс үзэхэд оролцогчдын 80 орчим хувь нь бүс нутгийг цэвэр аялал жуулчлалын бүс гэж үзсэн бол 68 хувь нь тус газрыг лус савдагтай гэдэгт итгэдэг харин 84 хувь нь хог хаягдлын зохисгүй менежментээс байгаль орчинд учруулах хор хохирлыг ойлгодог байна. Гэвч, энэ нь паркийн ихэнх зочид хогоо хууль бусаар хаях буюу байрласан буюу баяр тэмдэглэсэн газраа орхидог болох нь анзаарагджээ. Энэ нь зочид байгальд аялахыг зөвхөн хувийн хэрэгцээний үүднээс авч үздэг бөгөөд соёл уламжлал гээгдсэн болохыг харуулж байна. Иймээс, оюун санааны манлайлагчид, соёлын итгэл үнэмшилд дангаар суурилснаар БОБ-ын стратеги, компани ажил амжилтад хүрэхгүй байж болох юм.

Өмнө дурдсан 2019 оны НҮБХХ-ийн ENSURE төслийн МХД судалгаагаар гол оролцогч талууд, малчдын хэвлэл мэдээллийн хэрэгслийн сонголт, хандлагыг тодорхойлсон байна. Жишээ нь. Малчдын 60 хувь нь бэлчээрийн доройтол тэднээс хамаараагүй, 45 хувь нь байгаль өөрөө нөхөн сэргэнэ гэж үзэж байв. Харин тэд цаг уурын өөрчлөлтөөс (90%), засгийн газар арга хэмжээ аваагүйгээс (85%), ерөнхий хүний үйл ажиллагааны улмаас (70%) асуудал үүсэж байна гэжээ. Шийдвэрлэх арга замыг мал сүргийн менежмент (50%), бэлчээрийн зохистой хуваарилалт (21%), худаг гаргах (23%) гэж тодорхойлжээ. Нийт оролцогчдын 86 хувь нь онгон байгалийг хамгаалахад ТХГ шаардлагатай гэж хариулсан ч 55% нь энэ тэдэнд хамаагүй асуудал, байгалийн ашиг тусын (ж.нь 58% нь ирвэс, 45% нь хүдэр, тарвага) талаар “Мэдэхгүй” хариултыг олноор сонгосон байв.

2014, 2016, 2018 онуудад ДБХС-аас Хэнтий, Сүхбаатар аймаг дахь Хар Ямаатын байгалийн цогцолбор газрын ойролцоох 100 орчин оршин суугчдын дунд МХД судалгаа хийсэн байна. Хэдий ТХГ-ын тухай “маш сайн”, “сайн” мэднэ гэж хариулах болсон ч дийлэнх нь “бага зэрэг” эсвэл бүр “огт мэдэхгүй” хариултыг сонгосон байв: 2014 онд 72% / 12% , 2016 онд 59% / 5%, 2018 онд 39% / 3%. Оролцогчид мөн ТХГ-д явуулах үйл ажиллагаанд хамаарах хууль (36%), хариуцлагын (34%) талаар мэдлэггүй байв.

3.3 Мэдээлэл, харилцааны зорилт

Гол зорилтот бүлэгт өнөөг хүртэл тодорхойлоод байгаа асуудалд суурилан, мэдээлэл харилцааны зорилтыг доорх байдлаар тодорхойлж болох юм. Зорилтыг цаашид БОБ арга хэмжээгээр бий болгох мэдлэг (М), хандлага (Х) болон дадал (Д) орсон өөрчлөлтөөр тодорхойлох юм.

Асуудал	Үндсэн зорилтот бүлэг	Мэдээлэл харилцааны зорилт
Улс төрийн хүсэл зориг, санхүүжилт ба хүний нөөц дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ УИХ ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ■ бусад хамаарах эрх бүхий байгууллагууд ■ бусад улс төрийн шийдвэр гаргагчид 	<p>К Холбогдох засаг захиргааны байгууллага, албан хаагчид ТХГ-г тулгарч буй гол сорилт, аюул заналхийлэл, чиг хандлага болон санхүүжилт, хүний нөөцийн хэрэгцээг танин мэдэх</p> <p>А ТХГ системийг тогтвортой, ирээдүйд чиглэсэн арга хэлбэрээр дэмжих үр ашигтай нэн тэргүүний арга хэмжээний хэрэгцээ, шаардлагын мэдрэмжийг бий болгох Төрийн байгууллага, албан хаагчдын дунд улс төрийн хүсэл зориг дутмаг байдлаас үл хамааран үр ашигтай, зах зээлд суурилсан үр ашигтай, ТХГ-ын тогтолцоог дэмжих, хадгалах хууль эрх зүйн хөшүүрэг, торгуулийн арга хэмжээг бий болгох</p> <p>Р Газар, бэлчээрлэлт, аялал жуулчлалын тусгай зөвшөөрлийг үр ашигтай хязгаарлах ТХГ-ын үйл ажиллагааны төсөв/олон нийтийн процесст дархан газарт нэвтрэх/ан агнуурын хураамжийг нэмж тусгах Цоохор ирвэс болон түүнтэй адилтгах зүйлийн зураг авалтыг төлбөртэй болгож, ТХГ-ын 2020-2025 оны үндэсний шинэчилсэн төлөвлөгөөнд бэлчээрийн бэлчээр ашиглалт, аялал жуулчлал зэрэг байгаль орчинд сөрөг нөлөө бүхий бусад үйл ажиллагаатай үр дүнтэй тэмцэх зах зээлийн, эрх зүйн хөшүүрэг, торгуулийн арга хэмжээг тусгах. ТХГ-ын үндэсний төлөвлөгөөний дэд бүтэц, олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, мониторинг үнэлгээний хэрэгжилтэд зориулсан санхүүжилтийг хангалттай олгох ТХГ-ын үндэсний төлөвлөгөөний дэд бүтэц, олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, мониторинг үнэлгээний хэрэгжилттэй холбоотой хүний нөөцийг сургаж, гэрээлэх</p>
ТХГ-ын талаар олон нийтийн мэдээлэл дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ Сургуулийн багш нар ба сурагчид ■ эко-клубүүд ■ ТХГ-ын захиргаа/ байгаль хамгаалагчид ба Мэдээллийн төвүүд ■ орон нутгийн иргэд/малчид ■ хамгаалалтын бүсийн зөвлөлүүд ■ орон нутгийн ХМХ ■ ТББ-д ■ аялал жуулчлалын компаниуд 	<p>К ТХГ-ын байрлал, ёс зүйн журам, хэрхэн биеэ авч явах талаар мэдээллийг олон нийтэд хүргэх, ТХГ дахь экоосистемийг үйлчилгээ, тэдгээрийн хүний үйл ажиллагаатай холбогдох учир шалтгааны холбоосын талаар ойлголтыг сайжруулах</p> <p>А Монголчуудын байгаль орчноо хайрлан, дээдэлж ирсэн соёлын өв уламжлалыг өвлүүлэн, бахархах сэтгэлийг төрүүлэх</p> <p>Р ТХГ-ын гадаа орчинд зохион байгуулах АББОБ-ын заах арга зүйн чанарыг сайжруулах Жуулчдад зориулсан хэвлэмэл, цахим, сайт дах мэдээллийг нэмэгдүүлэх Аялал жуулчлалын компаниуд, хөтөч нарыг ёс зүй, хог хаягдал, эрүүл ахуйн боловсролыг түгээхэд сургах.</p>
Бэлчээрийн талхлагдалт, ойн сангийн доройтол, нөөцийн хэт ашиглалт	<ul style="list-style-type: none"> ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа малчид/орон нутгийн иргэд ■ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид ■ хамгаалалтын бүсийн зөвлөл ■ олон нийтийн нийгэмлэгүүд ■ зочид ■ нөөц ба ТБОБ хэрэглэгчид 	<p>К Нөөцийн ашиглалттай холбоотой Юуг, Хэн, Хэзээ, Хэрхэн асуултуудад хариулах олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэн, үүнээс шалтгаалан хүмүүсийн нийтлэг сайн сайхан, амьжиргаанд учруулж болох хор хохирлын тухай мэдэх</p> <p>К Малчид, зочдод бэлчээрийн талхлагдалт, ойн хомсдолын урт хугацааны хор нөлөөлөл, нийтлэг чиг хандлагын талаар мэдээлэл хүргэх</p> <p>А Байгалийн баялаг нь бүх нийтийн өмч болохыг, ямар учраас амин хувиа хичээсэн хандлагаас хамгаалах тухай ойлголтыг бий болгох</p> <p>А Хэрэв баялгийг тогтвортой бусаар ашиглаагүй нөхцөлд малчдын хүүхдүүдийн ирээдүй, амьжиргаанд нөлөөлөх бөгөөд байгаль эхтэй хүйн холбоотой болохыг</p>

Асуудал	Үндсэн зорилтот бүлэг	Мэдээлэл харилцааны зорилт
		<p>ухамсарлуулах</p> <p>Р Нөөцийн тогтвортой ашиглалтын ёс зүйг даган мөрдөх хүмүүсийн тоо нэмэгдэх</p> <p>Энгийн бэлчээрийн даацын загварын судалгаанд дэмжлэг үзүүлэх, бусад оролцогч талуудыг сургах</p>
<p>Жуулчлал хэт ихэссэн, мөн хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй</p>	<ul style="list-style-type: none"> ■ Орон нутгийн захиргаа ■ орон нутгийн иргэд, малчид ■ сургуулиуд ■ зочид ■ ТХГ захиргаа/ байгаль хамгаалагчид ■ ХХХ болон эрүүл ахуйн үйлчилгээний компаниуд ■ аялал жуулчлалын компаниуд 	<p>К Аялал жуулчлалын компаниудад ТХГ-ын аялал жуулчлалын гол чиг хандлаг, урт хугацааны үр нөлөөллийн талаар таниулах</p> <p>К Хог хаягдлын менежмент, эрүүл ахуйн эрүүл мэнд, сайн сайханд хэрхэн нөлөөлөх талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх</p> <p>А Аялал жуулчлалын компаниудын бизнес загварын үндэс болсон байгалийн баялгийг тогтвортой хадгалж чадаагүйгээс ирээдүйд учрах асуудлыг ухамсарлах</p> <p>А Эрүүл, цэвэр цэмцгэр ТХГ-аар бахархах, талархах сэтгэгдлийг төрүүлэх</p> <p>Р Үйл ажиллагаагаа ТХГ-ын даацад тааруулан явуулах аялал жуулчлалын оператор компанийн тоо нэмэгдэх</p> <p>Р Хог хаягдал, эрүүл ахуйн журмыг даган мөрдөх айл өрх, эдийн засгийн нэгжийн тоог нэмэгдүүлэх</p> <p>Байгаль хамгаалагчид, сургууль, аялал жуулчлалын операторууд, олон нийтийн оролцоотой төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хамтын менежментийг нэвтрүүлэх.</p> <p>ТХГ-ын журам, үүний дотор орон нутгийн хөтчийг жуулчдын бүлэгт холбох, ТХН-ын орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалт гаргах, орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчдэд анхан шатны англи хэлний сургалт өгөх зэргээр орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид/ олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх</p>

Мэдээлэл харилцааны зорилт нь бодлогын зорилттой ижил бус, бодлогын зорилт нь мэдээлэл харилцааны зорилтоос ялгаатай болохыг санах шаардлагатай. Жишээ нь, товхимол хэвлүүлэх, хурал зохион байгуулах нь БОБМХС-ийн чухал үйл ажиллагаа байж болох ч энэ нь зөвхөн арга хэлбэр бөгөөд зорилт үүгээр хязгаарлагдахгүй.

Дараагийн шатанд, ийм мэдээлэл харилцааны зорилтыг тухайн асуудлаас хамааруулан илүү дэлгэрэнгүй тодорхойлох шаардлагатай бөгөөд зорилтот бүлгийг ангилан, медиа бүтээгдэхүүн, харилцааны сувгийг тохируулж ашиглах шаардлагатай (**3.4-3.6 бүлгийг** үз).

3.4 Нөөц төлөвлөлт

БОБМХС хэрэгжүүлэхэд цаг хугацаа, хүн хүч, санхүүжилт зэрэг нөөц шаардлагатай. Эдгээр нөөцийг БОАЖЯ-ТХНУГ-ын БОБ-ын бүтээгдэхүүн, хэлбэрийг удирдан зохион байгуулж, санхүүжүүлэх чадавхад тохируулан үйл ажиллагааны төлөвлөгөөнд бодитойгоор тодорхойлох шаардлагатай (**4 бүлгийг** үз). БОБМХС болон холбогдох үйл ажиллагааны төлөвлөгөөнд өнөөгийн хэрэгжүүлж буй БОБ-ын бүтээгдэхүүн, тэдгээрийн хэлбэрүүд, мөн ойрын хугацаанд донорууд, ТББ-ууд зэрэг бусад талаас хэрэгжүүлэх бусад хөтөлбөрийг системтэйгээр нэгтгэх шаардлагатай (**3.5 болон 3.6 бүлгийг** үз)

Энэ үе шатанд стратеги хөгжүүлэлтийн бүхий л чиглэлээр (“Ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх?”) гэсэн асуултад хариулах ба, дараагийн үе шатанд менежментийн төлөвлөлтийн (“Хэрхэн гүйцэтгэх?”) гэсэн асуултад хариулна (**3.8 ба 3.9 бүлгийг** үз). Энэ ажиллагааг БОБМХС хөгжүүлэлтийн 1-3 шатны үр

дүнд сайтар дүн шинжилгээ хийж, 5-10 шатны бодит нөхцөл байдлыг тодруулах байдлаар хэрэгжүүлэх нь хамгийн үр дүнтэй.

3.5 Хамтын ажиллагаа

БОАЖЯ-ТХНУГ-ын хязгаарлагдмал санхүүжилт, хүний нөөцийн бололцооноос хамааран БОБ үйл ажиллагааг хамтран санхүүжүүлж хувь нэмэр оруулах стратегийн түншлэл байгуулах зайлшгүй шаардлагатай. Жишээ нь ГОУХАН-ийн SPACES хөтөлбөрөөс 2020-2021 онуудад БОБ-ын чиглэлээр хоёр интерактив сургалтын гарын авлага, хэрэгслүүдийг бэлтгэж, ТХГ-ын олон модульт ёс зүйн журам (ЁЗЖ) боловсруулан, ЁЗЖ-ыг танилцуулах зурагт видео клип хийлгэж, ТХГ-тай холбоотой үйл ажиллагаа, байршлыг агуулсан тараах материал, мэдээллийн самбарын стандарт загварыг боловсруулна. Үүнээс гадна ГОУХАН нь мэдээллийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн хөгжүүлэлтэд БОАЖЯ-ТХНУГ -т хувь нэмэр оруулах санхүүжилтийн гэрээг байгуулсан (дээрх жишээг үзнэ үү). Эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг БОБМХС-т нэгтгэн тусгахад БОАЖЯ-ТХНУГ-т мөн нэмэлт дэмжлэг, коучинг, сургалт шаардлагатай болно.

Үүнээс гадна БОБМХС-т хувь нэмэр оруулах НҮБХХ-ийн ENSURE төсөл, ЗААХН, ДБХС зэрэг бусад түншүүдийн мэдээллийг доор дурдав(3.6 бүлгийг үз).

Жишээ ГОУХАН-ийн 2020 оны санхүүжилтийн гэрээнүүд


- Монголын ТХГ-уудын газарзүйн атлас
- БОБ-ын чиглэлээр хүүхдийн цуврал ном
- Оюутан, сурагчдын дунд ТХГ-тай холбоотой эссэ/илтгэл, зургийн уралдаан
- Аяллын маршрут бүхий гар утасны апп
- Үндэсний биологийн төрөл зүйлийн мэдээллийн вэб хуудас, мобайл апп
- Биологийн олон янз байдлын мониторингийн талаар иргэний шинжлэх ухаанч үзэл баримтлал
- ТХГ-ын удирдлагыг сайжруулах хууль хэрэгжүүлэлтийн өгөгдлийн сан
- ТХГ-ын бэлэг дурсгалын зүйл, тараах материалын нэгдсэн загвар
- ТХГ-ын ажилтнуудын онлайн сургалт
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг сурталчлах тараах материал, зурагт хуудас, видео, компаниит ажил

3.6 Мэдээллийн хэрэгслийн сонголт, хольц

Байгаль орчны мэдээлэл харилцаа нь хүрээлэн буй орчны тогтвортой байдалд чиглэсэн үр дүнтэй бодлого тодорхойлох, олон нийтийн оролцоог хангах, төсөл хэрэгжүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор мэдээлэл харилцааны процесс, медиа бүтээгдэхүүн, харилцаа холбооны суваг, сургалтын хэрэгслийг тодорхой төлөвлөгөө, стратегитайгаар ашиглах явдал юм. Энэ тохиолдолд, байгаль орчны мэдээлэл харилцаа нь Монгол орны ТХГ-тай холбоотой байгаль орчны асуудлуудыг улс төрийн бодлого тодорхойлох болон олон нийтийн оролцоог хангах нийгэм-улс төрийн процесст холбох нэн чухал холбогч болох юм.

Судалгаа, туршлагаас үзэхэд олон нийтийн, бүлгийн, хүн хоорондын харилцааны хосолсон арга хэлбэрийг ашиглах нь хамгийн зардал багатай байна. Зорилтот бүлгийн дунд өмнө хийсэн судалгаа, МХД дүн шинжилгээ болон хамтын ажиллагааны урьдчилсан төлөвөөс харахад олон төрөлт мэдээллийн хэрэгслийг хослуулан ашиглах нь зүйтэй юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг зорилтот бүлгийн мэдээлэл олж авах дадал, сонгон хэрэглэх мэдээллийн эх үүсвэр, хүрэлцээ, мэдээллийн хэрэгслийг ашиглах арга барил, мэдээллийн сүлжээ, бүлгийн харилцааны зан үйлд нийцтэйгээр сонгох шаардлагатай.

Үүний үндэслэл нь харилцан уялдаатай, зохицуулагдсан мэдээлэл харилцааны систем нь зорилтот ашиг хүртэгчдийн тодорхой хэрэгцээ, асуудалд чиглэсэн тодорхой боловч ялгаатай мэдээлэл, хандлага, зан үйлийг шийдвэрлэх чадвартай байх ёстой. Бүхий л зорилтот бүлэг, бүх зорилтод нийцтэй мэдээллийн нэгдсэн нэг арга



хэрэгсэл гэж үгүй. Иймээс, мэдээллийн хэрэгслийг олон бус зөвхөн нэг буюу тодорхой мэдээлэл, боловсрол, харилцааны зорилтод зориулан сонгож ашиглах нь зүйтэй. Ялгаатай мэдээлэл харилцааны сувгууд харилцан бие биенээ нөхөн бэхжүүлэх ёстой. Тус бүртээ өвөрмөц шинж чанар, тодорхой давуу талтай тул тодорхой зорилтод хүрэхэд тустай юм.

2020 оны 1-2 дугаар сард хийгдсэн ЧХҮ-ний ярилцлагын дүгнэлтээр дараах томоохон хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны суваг, сургалтын хэрэглэгдэхүүнийг БОБМХС-ийн хүрээнд тодорхойлсон байна (Хавсралт 1-5-ыг үз).

Асуудал	Гол зорилтот бүлгүүд	Мэдээллийн хэрэгсэл, харилцааны суваг, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт.
Улс төрийн хүсэл зориг, санхүүжилт ба хүний нөөц дутмаг	<ul style="list-style-type: none"> ▪ УИХ ▪ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ▪ бусад холбогдох агентлагууд / эрх бүхий байгууллагууд 	<ul style="list-style-type: none"> ▪ Хөдөлгөөнт зурган клип ▪ Зураг, тоон мэдээлэл бүхий баримт/тараах материал (инфографик) ▪ онлайн TED илтгэлбаулс төрчдийг оролцуулсан экспертүүдтэй хийх телевизийн нэвтрүүлэг ▪ ТХГ-тай холбоотой санхүүжилт босгох, санал хөгжүүлэх сургалтын модул ▪ тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх заавар зэргийг агуулсан ТХГ-ын ажилтнуудын үндэсний нэгдсэн стандарт үйл ажиллагааны журам
ТХГ-ын талаар олон нийтийн мэдээлэл дутмаг	<ul style="list-style-type: none"> ▪ Сургуулийн сурагчид ба багш нар ▪ эко клубүүд ▪ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид, мэдээллийн төв орон нутгийн иргэд/малчид ▪ хамгаалалтын бүсийн зөвлөл орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ▪ ТББ-д ▪ аялал жуулчлалын компаниуд 	<ul style="list-style-type: none"> ▪ Албан бус байгаль орчны боловсролын (АББОБ) сургалтын хэрэгсэл ▪ Сургагч багш нарын сургалт (дахин, давтан), байгаль хамгаалагчид, орон нутгийн ТББ-ууд, залуучуудад зориулсан АББОБ-ын гадаа орчны хөтөлбөр, хэрэгслийн ашиглалт ▪ Хэрэгслийг ашигласан залуус, багш нарын АББОБ-ын гадаа орчны хөтөлбөр, аялал ▪ ТХГ-тай холбоотой театр, драмын дугуйлан ▪ ТХГ-ын ЁЗЖ-ыг агуулсан самбар, газрын зураг, замын тэмдэг, баримт, онлайн мэдээлэл ▪ (орон нутгийн) сэтгүүлчид, өөрчлөлтийн түүчээд, ТББ-дад зориулсан ТХГ-ын тухай сургалт ▪ Уран бүтээлийн уралдаан, үүний дотор сургууль, уран бүтээлчид, хувийн секторын НХ-ын хүрээнд ТХГ-дын үйлчилгээний талаар уран бүтээлийн тэмцээн зохион байгуулах ▪ ТХГ-ын хялбар ойлгомжтой вэв хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ба нийгмийн сүлжээний компаниит ажил ▪ Аялал жуулчлалын компаниудад ТХГ-ын танилцуулга, ёс зүйн журмын танилцуулга хүргүүлэх ▪ Бүргэдийн, тогоруун наадам гэх мэт наадам, үзэсгэлэнгийн арга хэмжээгээр орон нутгийн оршин суугчидтай биечлэн уулзах ▪ ТХГ-д зориулсан комикс, апп зэргийг хослуулан “Ногоон паспорт” гаргах ▪ И-Шувуу (E-Bird) зэрэг гар утасны мессеж, апп ашиглан иргэдэд шинжлэх ухаанчаар танилцуулна ▪ Залууст зориулсан QR код ашигласан VR зэрэг танилцуулга, комик боловсруулах ▪ Хөдөлгөөнт видео клип (What’s up, Facebook мессежээр дамжуулан)
Бэлчээрийн талхлагдалт, ойн сангийн доройтол, нөөцийн хэт ашиглалт	<ul style="list-style-type: none"> ▪ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ▪ малчид/орон нутгийн иргэд ▪ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид ▪ хамгаалалтын бүсийн зөвлөл олон нийтийн нийгэмлэгүүд ▪ зочид ▪ нөөц ба ТБОБ хэрэглэгчид 	<ul style="list-style-type: none"> ▪ Facebook бүлэг, ухаалаг гар утасны мессеж, апп ашиглан нийгмийн сүлжээний компаниит ажил зохион байгуулах ▪ ТХГ ба ёс зүйн журмын талаар самбар, газрын зураг, баримтын хуудас, онлайн мэдээллийн хэрэгсэл ▪ Баялгийн тогтвортой бус ашиглалтын асуудалба шийдэлтэй холбоотой мэдээлэл, танин мэдэхүйн хөтөлбөр (infotainment) басургуулийн театрын үйл ажиллагаа ▪ Бүх оролцогч талуудтай баялгийн тогтвортой ашиглалтын талаар зөвлөлдөх ▪ Өөрчлөлтийн түүчээ болсон тэргүүлэх малчдыг оролцуулсан малчдын уулзалт цуглаан ▪ наадам, үзэсгэлэнгийн арга хэмжээ, театр үзвэрээр дамжуулан мэдээлэл хүргэх ▪ малчид, орон нутгийн оршин суугчдыг баялгийн тогтвортой ашиглахад сургах ▪ олон нийтийн хэрэгслээр харилцан уялдаатай баялгийн тогтвортой ашиглалтын тухай нэвтрүүлэг цацах(малчин ТВ, МҮОНРТ, Эко-ТВ, Орон

Асуудал	Гол зорилтот бүлгүүд	Мэдээллийн хэрэгсэл, харилцааны суваг, сургалтын хэрэглэгдэхүүн гэх мэт.
		<p>нутгийн радио)</p> <ul style="list-style-type: none"> ▪ Малчид, орон нутгийн засаг захиргааг оролцуулсан нэвтрүүлгийг орон нутгийн радиогоор цацах
<p>Жуулчлал хэт ихэссэн, мөн хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Орон нутгийн засаг захиргаа ▪ орон нутгийн иргэд,үүний дотор малчид ▪ сургууль ▪ зочид ▪ ТХГзахиргаа/байгаль хамгаалагчид ▪ ХХХ, эрүүл ахуйн үйлчилгээний компаниуд ▪ аялал жуулчлалын компаниуд 	<ul style="list-style-type: none"> ▪ ТХГ-ын ЁЗЖ-ыг агуулсан самбар, газрын зураг, замын тэмдэг, баримт, онлайн мэдээлэл ▪ танин мэдэхүйн хөтөлбөр (infotainment) басургуулийн театрын үйл ажиллагаагаар ХХХМ, асуудал шийдлийг танилцуулах ▪ Бүх оролцогч талуудтай ХХХМ, ариун цэврийн байгууламжийн талаар зөвлөлдөх ▪ орон нутгийн засаг захиргаа, байгаль хамгаалагчид, аялал жуулчлалын компаниуд, ХХХ Компаниудыг оролцуулан олон нийтийн хэрэгслээр харилцан уялдаатайгаар аялал жуулчлалын шинэ үзэл баримтлал, ариун цэврийн байгууламжийн тухай нэвтрүүлэг цацах, ▪ Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд ивээн тэтгэсэн наадам, үзэсгэлэн, аялан тоглолт болон ХХХМ, ариун цэврийн байгууламжийн талаар WASH компаниг ажил, танин мэдэхүйн мэдээллийг театрчилсан тоглолтоор хүргэх ▪ Малчдын нөхөрлөлийн уулзалтаар аялал жуулчлалтай холбоотой үзүүлэх үйлчилгээг тодорхойлох ▪ Жуулчидтай харилцахад хэрэглэгдэх нийтлэг үг хэллэгийг багтаасан Англи/Монгол товхимол ▪ МҮОНРТВ болон орон нутгийн радиогоор сар тутмын хөтөлбөр нэвтрүүлэх

Мэдээлэл, харилцаа нь ТХГ-тай холбоотой асуудлыг шууд шийдвэрлэхгүй гэдгийг санах нь зүйтэй. Үүнээс гадна, доорх зорилгыг агуулсан зах зээлийн эдийн засагт суурилсан, хууль эрх зүйн хөшүүрэг шаардлагатай:

- Малчдын хувьд бэлчээрийн талхлалт, ж.нь малын хөлийн татвар, бэлчээрийн хураамж, мал сүргийн менежмент, чанарын тухай, эсвэл
- Аялал жуулчлалын компаниудад хэт олон жуулчинтай холбоотойгоор, ж.нь жуулчдын тоог тусгай зөвшөөрлөөр хязгаарлах, тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэх.

Дээрх хоёр тохиолдолд, арга хэмжээг татварын урамшуулал буюу зээл/тэтгэлэг/байгаль орчны урт хугацааны хөрөнгө оруулалттай эргэлтийн сан, уян хатан хяналт, мониторингийн систем зэргийг хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дараагийн үе шатуудад, тодорхойлсон хэвлэл мэдээлэл, харилцааны сувгууд, сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг тухайн асуудал, зорилтот бүлэг, харилцааны зорилтын ангиллаас хамааруулан сонгож, мэдээллийн бүтээгдэхүүн, харилцааны сувгийг ашиглана (**3.1-3.5 болон 4 бүлгийг** үз).Энэ зорилтын хүрээнд БОБМХС-д ГОУХАН (**3.5 бүлгийг** үз), болон ДБХС, НҮБХХ-ийн ENSURE төсөл зэргээс оруулах хувь нэмрийг та бүхэнд зориулан доор дурдлаа. Тэдгээрийн оролцоо нь БОБМХС-ийн Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэвлэл мэдээллийн хэрэгслийг үндэслэлтэй сонгоход дэмжлэг болох өгөгдөл, туршлагаар хангаж, эхлүүлэх цэг болж болох юм(**4 бүлгийг** үз).

Өмнө дурдсан НҮБХХ-ийн ENSURE төслөөс 2019 онд гүйцэтгэсэн МХД судалгаагаар холбогдох малчид болон бусад оролцогч талуудын ТХГ-тай холбоотой мэдээллийн хэрэгслийн сонголтыг тодорхойлсон байна. Байгаль орчин, хөдөө аж ахуйн мэдээллийн эх үүсвэрийн хувьд малчдын 91% нь үндэсний телевиз, 23% нь орон нутгийн телевиз, 15% нь интернэт, 9% нь үндэсний радио, 7% нь уулзалт, цуглаанаас, 4% нь айл саахалтынхнаас, мөн 2% нь мессеж, орон нутгийн радиогоос мэдээлэл авдаг байна. Эмэгтэйчүүд ТВ/вэб/айл саахалтынхан/мессежийг илүүтэй ашигладаг бол эрчүүд үндэсний радио телевиз, орон нутгийн радио сонсох нь элбэг. Өндөр настнууд мөн дээрх чиг хандлагатай адил байдаг бол, залуу үе интернэт, ухаалаг гар утасны үйлчилгээнд илүү найддаг байна. Хамгийн өргөнөөр хүрдэг суваг нь МҮОНРТ(76%), Малчин ТВ (68%) суваг байна. Малчин ТВ

сувгийн Facebook хуудас МҮОНРТ-ын хуудастай ижил хэмжээний хандалттай байна. Хамгийн их үздэг хөтөлбөр нь мэдээ (76%), малчны мэдээ (33%), малчдын дуу хөгжим (31%), олон ангит кино (18%), малчдын сургалт (14%), хүүхэлдэйн кино (5%), болон мал аж ахуйн нэвтрүүлэг (3%) байна. Хамгийн өндөр үзэлтэй үдшийн 6-11 цаг. р.м. Ерөнхийдөө оролцогч талууд тэргүүн туршлагын талаар гол мэдээллийг сургалт, уулзалт, ТВ сувгуудаас олж авдаг.

2020 онд НҮБХХ-ийн ENSURE төслөөс Малчин ТВ сувагтай хамтран орон нутгийн зорилтот бүлэг, ялангуяа малчдад бүх нийтийн цаг, нэрийн хөтөлбөрөөр дамжуулан тогтмол мэдээлэл түгээх болсон. Сэтгүүлчидтэй хамтран бэлтгэсэн мэдээллийг МҮОНРТ-ээр мэдээлэл нэвтрүүлэхийн зэрэгцээ, бэлэн хөтөлбөрийг орон нутгийн ТВ сувгуудаар нэвтрүүлэхээр бэлтгэж байна. Тусгайлан бэлтгэсэн үндэсний хэмжээний 10 минутын радиогийн хөтөлбөрийг МҮОНРТ-ийн радио сувагтай хамтран Мягмар гариг бүрийн 15.30-аас нэвтрүүлдэг. Мөн, төслөөс soundcloud.com үйлчилгээнд подкаст хийж, МҮОНРТ-ээр нэвтрүүлсэн сурвалжлага, радио нэвтрүүлгээ цацах болжээ. Малчдыг бага оврын транзистор радиогоор хангаснаар хөтөлбөрүүдийг хүлээн авах боломжтой болно. Төслөөс оршин суугчдад хэрхэн дэмжлэг үзүүлсэн болон тарвага, хүдэр, буга зэрэг амьтдын тухай богино видео хөтөлбөр бэлтгэж байна. Цоохор ирвэс,зээр, аргаль хонь, халиун буга зэрэг амьтдын тухай тараах материалыг хэвлэж орон нутгийн зорилтот бүлгийнхний онгон байгалийг хамгаалах тухай мэдлэгт зориулан түгээхээр боловсруулж байна. Төслийн вэб хуудас, Facebook хуудсанд ч мөн төслийн үйл ажиллагааны талаар сонин тогтмол нийтэлж байна. Засгийн газрын мэдээ, Зууны мэдээ зэрэг өдөр тутмын сонин хэвлэлээр өндөр настан, хотын иргэд, ялангуяа оффис, төрийн албан хаагчдад үзэл баримтлалын талаар мэдээллийг хүргэж байна. Үүнээс гадна, малчдад зориулсан Малчин сэтгүүлд сар тутмын булан гаргахаар төлөвлөжээ. Төсөл нь өөрийн зорилтот бүлгийг ан Malchin (Малчин) вэб хуудас хөгжүүлэх төлөвтэй байна. Эцэст нь ТХГ-тай холбоотой гудамжны самбарыг сум, аймгийн төвийн зам дагуу байрлуулахаар төлөвлөжээ.

Жишээ

НҮБХХ-өөс Горхи тэрэлжийн ТХГН-г 2019 онд хэрэгжүүлсэн хог хаягдлын менежментийн компанит ажил

НҮБХХ-өөс нийгэм, зан үйлд өөрчлөлт оруулах мэдээлэл харилцааны (SBCC) чиглэлээр гурван арга хэмжээ хэрэгжүүлсэн: 1. Байгалийн цогцолбор газрын хог хаягдал хамгийн ихтэй орчинд зүй зохистой зан үйлийн тухай мэдээллийн самбар байршуулах. 2. Хог хаягдлын цэгийн газрын зургийг орох хаалганы ойролцоо байрлуулах. 3. Цогцолбор газрын ойролцоо дэлгүүрээр хогийн цэгийн байршлыг тодорхойлсон газрын зураг бүхий хогийн уут тараах. Үүний үр дүнд хог хаягдлын 86% нь орох хаалганы ойролцоох хогийн саванд хийх болсон нь зорилтот 30%-иас 3 дахин давсан өндөр үр дүн юм. Хүмүүс зан үйлийг үйлдэхээс өмнө мэдээллийг урьдчилж хүргэхэд эерэгээр хүлээж авдаг байна. Хэрэв хүмүүс цэвэр орчинд аялах хүсэлтэй бол энэ жишгийг хадгалан хог хаяхгүй байхад тустай.

Хогийн савыг зайлуулсан ч хүмүүс хуучин хогийн цэгт хогийг хаясаар байв. Энэ нь тухайн орчинд нэгэнт тодорхой хэмжээний хог цугларсан бол энэ нь тухайн газрыг “зориулалтын” хогийн цэг гэж ойлгогдох бөгөөд, өмнө байгаагүй шинэ жишгийг бий болгодгийг харуулж байна. Энэ үйл ажиллагааны хамгийн нөлөөтэй чухал цэг нь дэлгүүр байв.

ДБХС-аас 2020 онд сарын хугацаатай Ногоон Дуу Хоолой компанит ажлыг тусгайлан зориулсан Facebook хуудсаар дамжуулан Экологийн цагдаатай хамтран зохион байгуулсан байна. Энэ хуудсын гол агуулга нь хог хаягдлын зохисгүй устгалд чиглэсэн бөгөөд энэ дадлаас зайлсхийхийг уриалдаг. Мессежийг голчлон эрх зүйн хэм хэмжээг заасан (“Болох!Болохгүй!”) мэдээлэл, хууль хэрэгжүүлэх, шийтгэлийн анхааруулга хэлбэрээр хүргэсэн.

Зэрлэг ан амьтдыг хамгаалах нийгэмлэгээс(ЗААХН) 2009-2012 онд зээрийн агнуурын чиглэлээр хэрэгжүүлсэн ЗААХН-ийн PRIDE компанит ажил (“Эрүүл орчин, эрүүл иргэд”)–ын хүрээнд оршин суугчид, наймаачид, байгаль хамгаалагчид, малчдын дундч МХД судалгааг 2012 онд МХД судалгааг хийсэн байна. Энэхүү кампанит ажил нь ан агнуурын зөвшөөрлийн тухай ойлголтыг малчдад хүргэн, дэмжлэг авч, сумдын сайн дурын байгаль хамгаалагчдад танилцуулах зорилгоор оролцогч талуудын уулзалт зохион байгуулахад чиглэн, сумын анчдын дунд хууль эрх зүйн мэдээллийг түгээхийг зорьсон юм. Асуудалд дэмжлэг үзүүлэхээр анчид, гол оролцогчид талуудад зөв зохистой мэдээллийг FM радио, ТВ сувгаар нэмэлтээр хүргэжээ. Нүүдлийн байгаль хамгаалах ТББ-аас байгаль орчны боловсролын (“нүүдэлчин хайрцаг”) сургалт мөн ухуулах хуудас, товхимол бүхий компанит ажлыг малчид, олон нийтийн тэргүүлэгчид, болон гол оролцогч талуудын ажилтнуудад зохион байгуулсан байна. Голчлон хүн хоорондын харилцаанд суурилсан уг ажиллагаагаар анчид хуулийн шинэ зохицуулалттай танилцан, компанит ажлын гол зорилт болсон шинэ хууль, зохицуулалтыг өмнө мэддэг байсан мэт өндөр төвшинд даган мөрдөх болжээ. Анчид зэрлэг ан, амьтныг хамгаалах журмыг

даган мөрдөхөөр “санал нийлж байна” гэсэн хариуг өгснөөр тоо толгой нь 29% -42% хүртэл өссөн байна. Монголын зээрийн тоо толгойд учруулах аюул заналхийллийн тухай бусдад ярьж танилцуулсан анчдын тоо 33% - 72% хүрч өссөн байна. Сайн дурын байгаль хамгаалагчид анчдад ихээхэн нөлөө үзүүлсэн болно.

3.7 Мессежийн загвар

Мэдээлэл харилцааны стратегийн үр дүнтэй байдал ерөнхийдөө уг мэдээлэл зорилтот бүлгийн анхаарлыг татаж чадаж байгаа эсэх, ойлгомжтой байдлаас ихээхэн хамаарна. Иймээс мессежийг тухайн зорилтот бүлэг, ашиг хүртэгсдийн бүлгийн нийтлэг шинж, боловсрол, оюунлаг байдал, хүсэл эрмэлзэл зэрэгт тохируулан боловсруулах шаардлагатай. Мөн зохистой мэдээллийн хэрэгсэл сонгох ёстой.

Мэдээг амжилттайгаар хүргэхийн тулд маркетингийн чиглэлээр өргөн ашиглагдах энгийн хялбар байх *KISS (Keep it short and simple)* болон зорилтот бүлгийн *Анхаарлыг* орж, *Сонирхлыг* татан, *Хүсэл* төрүүлэн, *Үйлдэл* хийлгэх *AIDA(Attention, Interest, Desire, Action)* зарчмуудыг баримтлах шаардлагатай. Үүнээс гадна мэдээлэл нь хүртээмжтэй, үнэн зөв, батлагдах, бүрэн, зохистой цаг хугацаанд, ач холбогдолтой байх хэрэгтэй.

Мэдээллийг байршуулахдаа үнэн зөв, хамааралтай байдлыг баталгаажуулж, мэдээлэх, сэдэлжүүлэх, эсвэл уриалан дуудах зорилго буюу стратегийн асуудалдаа тохируулан сэдэв, мессеждээ төвлөрөх шаардлагатай.

Эрх зүйн хэм хэмжээг заасан (“Болох!Болохгүй!”) мэдээлэл хүрэхдээ муу тул сэдвийн мессежийг айдас-сэдэл, урам зориг, үлгэр дуурайл, иргэний үүрэг гэх мэт нийгмийн буюу сэтгэл зүйн аргаар анхаарал татахуйцаар "савлан" анхаарал татаж, ятган сэнхрүүлэхээр боловсруулах хэрэгтэй юм. Мөн, сэдэвт стратегийн зорилтыг баримтлахын зэрэгцээ, хошигнол, нийтлэг асуудал, баримт, дүгнэлт зэргийг агуулсан байж болно.

Мессежийн загвар төсөл нь зорилтот бүлэг, асуудал, сэдвээс хамаарна. Ялангуяа мэдээллийн урсгал өндөртэй хотын иргэд, залуу үед чиглэсэн мэдээлэлд энэ ихээхэн хамааралтай. Иймээс, мэдээллээр тодорхой зорилтот бүлэгт итгэл үнэмшил төрүүлж, дагуулахын тулд дор хаяж хагас жилийн турш тогтмол мэдээллийг, агуулгын чанарыг сайжруулан хүргэх шаардлагатай болно. “Хол явах гэвэл Ойроос эхэл Ихийг хийх гэвэл Багаас эхэл”¹ хэмээх Монгол ардын зүйр цэцэн үгт хэлсэнчлэн бага багаар, тасралтгүй мэдээлэл хүргэх учиртай.Зөв, тодорхой, товч мэдээлэл нь ТХГ-ын талаар ойлголт, экосистем, биологийн олон янз байдлыг хадгалахад тэдний үүрэг ролийг дээшлүүлэхэд түлхэц болно.

Одоогоор ангилан тодорхойлсон асуудал, гол зорилтот бүлгүүдийн хүрээнд хүргэх гол мэдээллийг доорх байдлаар тодорхойлж болно. Мэдээлэл нь цаашид БОБ-ын цаашдын арга хэмжээгээр бий болгох мэдлэг (М), хандлага (Х), дадалд (Д) орох өөрчлөлтүүдээр ялгагдана.

Асуудал | Гол зорилтот бүлгүүд | Гол мессеж (Мэдлэг-Хандлага-Дадал)

Жишээ ТХГ-ын ёс зүйн журмын мэдээллийн загвар

Хориглосон, сөрөг утгатай мэдээлэл нь ихэнхдээ эерэг үйлдэл, өөрчлөлтийг бус тааламжгүй сэдэл, эсэргүүцэх хандлагыг төрүүлдэг. Иймээс, олон нийтийн зан үйлд байгаль орчныг хайрлан, дээдлэх нь тухай санааг биологийн олон янз байдлын алдагдалтай дор хаяж ижил төвшинд авч үзэх шаардлагатай. “Love not Loss/Хайрлах уу, хайхрахгүй юу, Алах бус аврах/” нь байгаль орчны хамгааллын үйл ажиллагаанд өргөнөөр ашиглагддаг маркетингийн уриа юм. Жишээ нь ГОУХАН-ийн SPACES төслийн боловсруулсан ТХГ-ын ёс зүйн журам “Have Fun – Take Care/Зугаатай ч сэрэмжтэй/” уриан дор ТХГ-д зочлон байгаль орчинд таатай амрахдаа, байгаль орчны эрүүл тэнцвэртэй байдлыг хангахын тулд зайлсхийх зүйлсийг нь сануулсан

¹Don't stuff a whole bread into a person's mouth but cut it into small loaves, flavored with cream and fruit jams

Асуудал	Гол зорилгот бүлгүүд	Гол мессеж (Мэдлэг-Хандлага-Дадал)
Улс төрийн хүсэл зориг, санхүүжилт ба хүний нөөц дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ УИХ ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ■ бусад холбогдох агентлагууд/ эрх бүхий байгууллагууд 	<p>К Монгол орны ТХГ-ын системийн талаар таны мэдэхэд илүүдэхгүй 10 баримт: гол сорил, аюул, чиг хандлага, нөлөөлөх зүйлс, шийдвэрлэх боломж, тэргүүн туршлага</p> <p>А Улс орныхоо ирээдүйн төлөө- Улс орны эдийн засаг, ард олны амьжиргааны эх үүсвэр болсон байгалийн баялгийг бүү устга</p> <p>Р Бэлчээрийн талхлагдалт, хэгийдсэн жуулчлал, бусад байгаль орчинд хортой үйл ажиллагаатай тэмцэх зах зээлд суурилсан, хууль эрх зүйн хөшүүрэг бүхий ТХГ-д холбогдох бодлого, хууль эрх зүйн хүрээг тодорхойлох</p> <p>ТХГ-ын үндэсний төлөвлөгөөний дэд бүтэц, олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, мониторинг үнэлгээний хэрэгжилтэд зориулсан санхүүжилтийг хангалттай олгох</p> <p>Хууль эрх зүйн хүрээнд ТХГ-ын үндэсний төлөвлөгөөний дэд бүтэц, олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, мониторинг үнэлгээний хэрэгжилттэй холбоотой хүний нөөцийг бэлтгэх</p>
ТХГ-ын талаар олон нийтийн мэдээлэл дутмаг	<ul style="list-style-type: none"> ■ Сургуулийн сурагчид ба багш нар ■ Эко клубүүд ■ ТХГ захиргаа/байгаль хамгаалагчид ба Мэдээллийн Төвүүд ■ Орон нутгийн иргэд / малчид ■ Хамгаалалтын бүсийн зөвлөл ■ Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ■ ТББ-д ■ Аялал жуулчлалын компаниуд 	<p>К ТХГ-ын тухай мэдэхэд илүүдэхгүй 10 баримт</p> <p>Байгаль орчин таны ирээдүй, эрүүл мэнд, сайн сайханд хэрхэн нөлөөлөхийг мэдэх</p> <p>Зочдын менежментийн арга хэмжээний стратегийн зорилтыг ойлгомжтой тодорхойлох.</p> <p>А Амьтан, ургамал, байгалийн тогтцыг хайрлан хамгаалах Монголчуудын соёлын өвөөр бахархах</p> <p>Сайн сайхан маргаашийн төлөө бид өнөөдөр !</p> <p>Эгог бус экологийг сонгох! Зөвхөн хувийн сонирхлоо бус, ТХГ-ыг бүхэлд нь харах</p> <p>Хүүхдийн ирээдүйн төлөө-Амьжиргааны эх үүсвэр болсон байгалийн баялгаа бүү устга</p> <p>Байгаль орчин таны төлөө бус, та байгалийн төлөө юу хийж чадах вэ</p> <p>Танд амьдрал өгсөн байгалийн ачийг өдөр бүр санаж явах</p> <p>Р Тодорхой ТХГ-д гадаа зохиогдох сонирхолтой ABC үйл ажиллагаа/ байгаль орчны XYZ санаачлагад оролцох / environmental</p> <p>Мэдээллийн самбар босгож, боловсролын мессежийг түгээх</p>
Бэлчээрийн талхлагдалт, ойн сангийн доройтол, нөөцийн хэт ашиглалт	<ul style="list-style-type: none"> ■ Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа ■ Малчид/Орон нутгийн иргэд ■ ТХГ захиргаа /Байгаль хамгаалагчид ■ Хамгаалалтын бүсийн зөвлөл ■ олон нийтийн нийгэмлэгүүд ■ Зочид ■ Нөөц ба ТБОБ хэрэглэгчид 	<p>К Бэлчээрийн талхлагдалтын талаар таны мэдэхэд илүүдэхгүй 10 баримт</p> <p>Байгалийн баялгийн тогтвортой ашиглалтын тухай таны мэдэхэд илүүдэхгүй 10 баримт: Юуг-хэн-хаана-хэзээ-хэрхэн, гэх мэт.</p> <p>Байгалийн баялгийн онгой ашиг тусыг, хамгаалах учир шалтгааныг олж мэдэх</p> <p>А Хүүхдийн ирээдүйн төлөө-Амьжиргааны эх үүсвэр болсон байгалийн баялгаа бүү устга</p> <p>Бэлчээр танд биш ирээдүйн өмч болохыг санах</p> <p>Эгог бус экологийг сонгох! Зөвхөн хувийн сонирхлоо бус, ТХГ-ыг бүхэлд нь харах</p> <p>Бүх нийтийн өмчийг хувиа бодож ганцаараа бүү ашигла</p> <p>Р Бэлчээрийнхээ даацад тааруулж мал сүргээ өсгөх</p> <p>Буцааж ургуулж чадахаасаа илүүг бүү ав</p>

Асуудал	Гол зорилгот бүлгүүд	Гол мессеж (Мэдлэг-Хандлага-Дадал)
Жуулчлал хэт ихэссэн, мөн хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламж шаардлага хангахгүй	<ul style="list-style-type: none"> ■ Орон нутгийн захиргаа ■ Орон нутгийн иргэд, үүний дотор малчид болон ■ Сургуулиуд ■ Зочид ■ ТХГ-ын захиргаа/байгаль хамгаалагчид ■ ХХХ болон эрүүл ахуйн үйлчилгээний компаниуд ■ Аялал жуулчлалын компаниуд 	<p>К ТХГ-д аялахтай холбоотой таны мэдэхэд илүүдэхгүй 10 баримт ХХХ-ын менежментийн тухай таны мэдэхэд илүүдэхгүй 10 баримт ХХХ-ын зохистой менежмент, дахин боловсруулалтын гол ач холбогдол, таны эрүүл мэнд сайн сайханд хэрхэн нөлөөлөх тухай мэдэж авах</p> <p>А Хүүхдийн ирээдүйн төлөө-Амьжиргааны эх үүсвэр болсон байгалийн баялгаа бүү устга Эгог бус экологийг сонгох! Зөвхөн хувийн сонирхлоо бус, ТХГ-ыг бүхэлд нь харах Харж баясах баялаг эрүүл, цэвэр цэмцгэр ТХГ-ын орчинг бүү сүйтгэ Эгог бус экологийг сонгох! Зөвхөн хувийн сонирхлоо бус, ТХГ-ыг бүхэлд нь харах Сайн/Бахархалт Монголчууд хог хаядаггүй!</p> <p>Р ТХГ-ын даацад тохирсон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх Хог хаягдлыг түүж, хог хаягдлын цэгт хая</p>

Мэдээлэл харилцааны зорилт (3.3 бүлгийг үз) мессежийн хоорондын гол ялгаа нь экосистем, биологийн олон янз байдлын тухай шууд ТХГ-д хамааруулан илэрхийлэх шаардлагагүйд оршино. Ихэнх хүмүүс ийм нарийн төвөгтэй, дийлэнхдээ эмзэг асуудлыг сонирхох нь бага байдаг. Тэдний сонирхох зүйл нь: “Надад, миний бүлэг, хамт олонд энэ ямар хамааралтай вэ? Надад, миний хүрээлэлд энэ хэрхэн нөлөөлөх вэ?” Тэд урамшуулал, ашгийн хөшүүргийг илүү сонирхож, энэ давуу боломжийг ашигласны төлөө ямар үнэ төлбөр төлж, хүчин чадал гаргах ёстойгоо мэдэхийг хүснэ. Жишээ нь: “Та ТХГ-ын асуудлуудыг шийдвэрлэхээр бусад оролцогч талуудтай хамтран энэ харилцан ярианд оролцсоноор та бүхэн өөртөө, өөрийн бүлэгт илүү ашигтайгаар бодлого, журмын төсөлд нөлөөлөх боломжтой юм.”

БОБМХС-ийн үр ашигтай байдал нь үндсэндээ мэдээллийг хэр ойлгомжтой, зорилтот бүлгийн анхаарлыг татахуйцаар боловсруулснаас хамаарна. Мэдээллийг БОАЖЯ-ТХНУГ-ын экспертүүд бус зорилтот бүлгийн гишүүд ойлгох ёстой. Аливаа мессежийг иймээс тухайн ашиг хүртэгсдийн бүлгийн нийтлэг шинж, боловсрол, оюунлаг байдал, хүсэл эрмэлзэл зэрэгт тохируулан “Дэгээндэх өтийг загасчинд бус загас амтална” гэдгийг санаж боловсруулах шаардлагатай.



Дараагийн шатуудад ийм мессежийг тухайн, зорилтот бүлгээс хамааруулан ангилж, зорилт, болон мэдээллийн бүтээгдэхүүний төрөл, ашиглах мэдээлэл харилцааны сувагт тохируулан илүү дэлгэрэнгүй боловсруулна (3.1-3.6 бүлгийг үз).

3.8 Мэдээллийн медиа бүтээгдэхүүн хөгжүүлэлт, урьдчилсан туршилт

Мэдээллийн медиа бүтээгдэхүүн, материалыг БОБМХС-ийн боловсруулалтын эхэн үед хэт олноор гаргахаас татгалзах нь зүйтэй. Медиа бүтээгдэхүүнийг төлөвлөж, цаг хугацаанд нь хэрэгжүүлэн, мэдээллийн хэрэгслийг зөвлөмжийн дагуу зохистой ашиглан, зохицуулснаар мультимедиа мэдээлэл, харилцааны стратеги амжилттай хэрэгжих илүү боломжтой. Боломжтой тохиолдолд энэ процесст оролцогч бүхий л талуудыг зохистойгоор сургах шаардлагатай. Стратеги хэрэгжүүлэлтийн нөлөө, үр дүнг үүний салшгүй хэсэг болох форматив болон нийлмэл үнэлгээний аргаар үнэлэх нь зүйтэй (3.10-р бүлгийг үз).

Ерөнхийдөө, бүхий л медиа бүтээгдэхүүн хөгжүүлэгч, дизайнеруудад мэдээлэл харилцааны материалын агуулга, загвар, ятган сэнхрүүлэх, татах харьцааг харгалзах тухай мэдээлэл өгөх шаардлагатай. Материал тус бүрт харгалзсан нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, бүх ажилтнууд, оролцоо, цаг хугацааны тухай мэдээллээр хангагдсан байна. Мэдээлэл, харилцааны экспертийг тодорхой даалгавартайгаар, жишээ нь их хэмжээний материал боловсруулахын өмнөх тусгай туршилт зэрэг ажлыг гүйцэтгүүлэхээр ажиллууулж болно. Үйл ажиллагааны нэгдсэн хуваарьт төлөвлөгөөнд бүхий л ашиглах медиа хэрэгслийг нарийвчлан тодорхойлсон байна. Доор үзүүлсэнтэй ижил төстэй төлөвлөлтийн хэрэгслийг БОБМХС-ийн 4-р үе шатанд (3.4-р бүлгийг үз) тусгасан боловч энэ үе шатанд бүрэн тодорхойлно.

Харилцааны суваг (медиа, мэдээлэл солилцох платформ, сургалтын хэрэглүүр)	Зорилгот бүлэг (үндсэн оролцогч талууд)	Мэдээлэл харилцааны агуулга	Бүтээх ба түгээх үүрэг (зууч ба түншүүдийг оролцуулан)	Төсөв ба бусад эх үүсвэр (хүний нөөц, ложистик зэрэг)	Хугацаа

Дээрх 3.5, 3.6 бүлэгт дурдсанчлан БОАЖЯ-ТХНУГ-ын хамтран ажиллагч ГОУХАН, ЗААХН, ДБХС, НҮБХХ болон бусад байгууллагуудын зүгээс ТХГтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр мэдээллийн медиа бүтээгдэхүүнийг төрөл бүрийн мэдээлэл харилцааны суваг, сургалтын хэрэглэгдэхүүнд зориулан боловсруулж, хөгжүүлж эхэлсэн байна. Хэрэв эдгээр үйл ажиллагааг цаг хугацааны хувьд харилцан бие биеэ нөхөн бэхжүүлэхээр зохион байгуулж чадвал (3.4 бүлгийг үз) бие даасан үйл ажиллагааны үр дүн олон дахин үржигдэнэ. Иймээс, сайтар зохицуулагдсан олон оролцогч талт чиг хандлагыг баримтлан, үр дүнд нь нэгдсэн Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж болох юм (4 бүлгийг үз).

3.9 Медиа бүтээгдэхүүний ашиглалт ба хэрэгжүүлэлт

БОБМХС-ийн энэ шатанд стратеги хөгжүүлэлтээс процессын менежмент төлөвлөлтөд шилжинэ. Мультимедиа мэдээлэл харилцааны стратегийн хэрэгжүүлэлтэд чухал үйл ажиллагааны хариу сэтгэгдлийг зохион байгуулагчдад даруй хүргэж, үүгээрээ шаардлагатай бол стратегид засвар, өөрчлөлт оруулах боломж олгодог сайн мэдээллийн удирдлагын систем шаардлагатай. Энэ мэдээллийн систем нь мөн, ихэвчлэн нэгэн зэрэг зохион байгуулах шаардлагатай, ялангуяа БОАЖЯ-ТХНУГ-ын түншүүд болох ГОУХАН, ЗААХН, ДБХС, НҮБХХ зэрэг байгууллагуудын өөр өөр төслүүдийн хүрээнд хэрэгжүүлэх, олон төрлийн үйл ажиллагааг зохистойгоор зохицуулах үүрэгтэй байна (3.5 ба 3.6 бүлгийг үз).

Иймээс, цаг хугацааг бодитой төлөвлөхийн тулд медиа хэрэгслийн төрөл, нийгмийн бүлэг бүрт хамгийн зохистой үйл ажиллагаа, үйл явдал, хугацаа, байршлыг сайтар сонгох шаардлагатай. Хэрэв боломжтой бол үүнийг олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өгөгдөл, Боломжтой бол үүнийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй уялдуулан уралдаан тэмцээнд түрүүлсэн, эсвэл байгаль орчинд ээлтэй бүх нийтэд тустай үйл ажиллагаанд оролцсоноор бахархуулах, олон нийтэд таниулах зэргээр мөнгөн бус урамшуулалтай хослуулан хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн төрөл бүрийн мэдээлэл, харилцааны сувгууд нь, ж.нь, театраар түүх өгүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэтгэл хөдлөм мэдээллийг давтах зэргээр “харилцан-үр өгөөжтэйгөөр” дэмжих шаардлагатай. Олон төрлийн мэдээллийн хэрэгслийн харилцан үржигдэх үр нөлөөллийг ж.нь. эко-клубийн оюутнуудын театрчилсан тоглолтын талаар ТВ-н нэвтрүүлэг хийх зэргээр төлөвлөгөөтэйгөөр ашиглах нь зүйтэй. Давтан хэлэхэд, ийм зохицуулалт, харилцан нөхөх боломжийг хамтрагч талуудын хил дамнасан

төслүүдтэй ч хэрэгжүүлэх боломжтой. Энэ зорилгоор, хэд хэдэн хамтрагч талуудын хамтарсан медиа ажиллагаа, наадам, өндөр хэмжээний зочдын айлчлал зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах зэргийг зохион байгуулах боломжтой. БОАЖЯ-ТХНУГ-ын хувьд ийм платформ ашиглах нь, өнөөгийн мэдээлэл харилцааны сувгийг чөлөөтэй ашиглах буюу бусад байгууллагуудын салбар төсвөөс ашиглан “туулайчлах²” аятайхан боломж болох юм.

3.10 Процессын баримтжуулалт, Мониторинг үнэлгээ

БОБМХС төлөвлөгчдийн хувьд стратеги хөгжүүлэлтийн бүхий л шатанд үнэлгээг тасралтгүй хийх ёстой. Үүний үндсэн чиглэл нь хэрэгжүүлэлтийн оновчтой байдал, үйл ажиллагааны үр ашиг, байгаа олсон эсэх, мөн хамгийн гол нь ерөнхий стратегийн нөлөөлөл, үр дүнг тодорхойлох явдал юм.

Олон төрлийн үнэлгээ хийгдэж болох бөгөөд: Таамаглалд суурилсан үнэлгээ нь ямар үр дүн хүлээхийг тооцоолох төлөвлөлтийн арга барил юм. Форматив үнэлгээгээр хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад зүг чигээ баримталж буй эсэхийг үнэлнэ. Хэрэгжүүлэлтийн дараа хийгдэх дагалдах үнэлгээ нь үйл ажиллагааны үр дүн, тогтвортой байдлыг үнэлнэ. Ихэнхдээ зорилтот бүлгийн дунд мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох МХД судалгааг төсөл буюу стратегийг хэрэгжүүлэлтийн эхэнд болон төгсгөлд хийж гүйцэтгэдэг.

Ийм мэдлэг, хандлага, дадалд орсон өөрчлөлтийг тодорхойлох өмнөх/дараах төлөвийн судалгаа нь хэвлэл, мэдээллийн сувгийн үр нөлөөлөл, БОБ арга хэмжээний чиглэлээр ашигласан сургалтын материалд хяналт, үнэлгээ хийхэд онцгой ач холбогдолтой.

МХД судалгаа хийх боломжгүй бол мониторинг үнэлгээний зардал багатай, нарийн төвөгтэй бусад аргуудыг хэрэглэх нь бий. Хамгийн чухал асуудал нь амжилтыг хэрхэн олж харах вэ гэдэгт онцгой анхаарах шаардлагатай: Та зорилтдоо хүрсэн эсэхээ хэрхэн харж, сонсож, мэдрэх вэ? Хүн бүр аливааг өөр өөрөөр харж тайлбарлах учир, үнэлгээний хоёрдахь чухал асуудал нь үүнийг хамт олноороо буюу оролцогч талуудын төлөөлөгчдийн уулзалтаар үнэлэх явдал юм.

БОБМХС-ийн төлөвлөлт, хэрэгжүүлэлт, менежментийн үе шатуудад амжилттай, амжилтгүй гаргасан шийдвэрүүдийг он цагийн дарааллаар жагсаан дүн шинжилгээ хийснээр, үүнийг ерөнхий нь цаашдаа Монгол Улсад ТХГ-ын БОБ-ын чиглэлээр ижил төстэй үйл ажиллагааг давтан хэрэгжүүлэхэд ашиглаж болно. Иймээс БОБМХС-ий г хөгжүүлж эхлэхээс эхлэн чухал асуудлууд, шийдвэр гаргахад тавих шаардлагын процессыг баримтжуулах шаардлагатай.

4. БОБМХС Үйл ажиллагааны төлөвлөгөө

Дээрх 3.8 бүлэгт дурдсанчлан ТХНУГ-аас Үйл ажиллагааны төлөвлөгөөг аль болох түргэн хугацаанд боловсруулах шаардлагатай. Үүнийг ГОУХАН-ийн SPACES төслийн баг болон бусад оролцогч талуудтай уулзалт зохион байгуулах замаар хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй. Энэ нь сайтар зохицуулагдсан, олон талт арга барилын суурийг тавьж, үр дүнд нь нэгдсэн Үйл ажиллагааны төлөвлөгөөнд цаг хугацаа, бүтээсэн медиа/сургалтын хэрэглүүр/ ашигласан мэдээлэл харилцааны суваг, хүрсэн зорилтот бүлэг, хамтрагч, түншүүд/бүтээлчид/ зуучлагчид, төсөв болон бусад шаардлагатай нөөцийг нэгтгэн тусгах юм.

²piggy-backing